МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

“МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ”

Судалгааны код: **БГСТ-24/013**

ЗАХИАЛАГЧ: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн

ГҮЙЦЭТГЭГЧ: Доктор, профессор Б.Эрдэнэчимэг

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

УДИРТГАЛ 4

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАДААД ОРЧНЫ МӨН ЧАНАР.....6

1.1. Гадаад бодлогын шийдвэр гаргалт.....7

1.2. Хөршийн харилцааны мөн чанар 8

1.3. Хамтын аюулгүй байдлын тогтолцоо 10

ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАДААД ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....13

2.1. Гадаад бодлогын үндсэн зарчим, шийдвэр гаргалт 13

2.2. Хоёр хөршийн харилцааны өнөөгийн байдал.....16

2.3. “Гуравдагч хөрш”-ийн харилцааны өнөөгийн байдал 22

2.4. Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа.....26

2.5. Монгол Улсын аюулгүй байдлыг баталгаажуулах асуудлаарх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолууд 27

2.6. Бүс нутгийн тогтвортой байдал, аюулгүй байдлын хамтын ажиллагаа 29

ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ОЛОН УЛСЫН ГЕОПОЛИТИК, ГАДААД ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛ 33

3.1. АНУ, БНХАУ-ын хооронд үүсэж болзошгүй харилцааны Монгол Улсын аюулгүй байдалд учрах боломж, эрсдэл.....35

3.1.1. Америк, Хятадын хооронд үүсэж болзошгүй сөргөлдөөний үед учрах эрсдэл..... 36

3.1.2. Америк, Хятадын хоорондын харилцаа хоршсон үеийн боломж, өрсөлдсөн үеийн эрсдэл.....37

3.2. АНУ, ОХУ-ын хооронд үүсэж болзошгүй харилцааны Монгол Улсын аюулгүй байдалд учрах боломж, эрсдэл 38

3.2.1. Америк, Оросын хоорондын харилцааны сөрөг үед учрах эрсдэл 38

3.2.2. Америк, Оросын соёл иргэншил хоорондын харилцааны үеийн боломж, эрсдэл 40
3.3. ОХУ, БНХАУ-ын хооронд үүсэж болзошгүй харилцааны Монгол Улсын аюулгүй байдалд учрах боломж, эрсдэл.....42
3.3.1. Орос, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хэвийн үргэлжлэх үеийн боломж.....42
3.3.2. Орос, Хятадын хооронд үүсэж болзошгүй зөрчилдөөний үед учрах эрсдэл 45

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЗӨВЛӨМЖ.....46
4.1. Бодлого, эрх зүйн орчны хүрээнд авч хэрэгжүүлэх зөвлөмж.....46
4.2. Бодлогын хэрэгжилтийг сайжруулах талаарх зөвлөмж.....47

ЭШЛЭЛ АВСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ 50

УДИРТГАЛ

Судалгааны ажлын үндэслэл:

Монгол Улсын оршин тогтнохуйн аюулгүй байдлын тулгуур асуудлууд болох тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн халдашгүй байдал, соёл иргэншлийн аюулгүй байдалд хоёр хөрш орноос явуулж буй бодлого, үйл ажиллагаанаас гадна дэлхийн дэг журмыг тогтооход голлох үүрэг гүйцэтгэдэг их гүрнүүдийн бодлого, ашиг сонирхол нөлөөлдөг.

Монгол Улсын газарзүйн онцгой байрлал нь бидний аюулгүй байдал, ирээдүйн хөгжлийг тодорхойлж байдаг. Өөрөөр хэлбэл, ОХУ, БНХАУ ба АНУ гэсэн дэлхийн гурван их гүрний хоорондын харилцаа, хүчний харьцааны өөрчлөлтөөс ихээхэн хамаарна.

Аюулгүй байдлын гадаад орчны ийм онцгой нөхцөлд Монгол Улс аюулгүй байдлаа улс төр-дипломатын аргаар хангах төрийн бодлогын үүрэг, ач холбогдол улам өндөр болж байна. Иймд ухаалаг, идэвхтэй гадаад бодлого, үйл ажиллагаа, харилцан итгэлцсэн, найрсаг, хамтын ажиллагааг хөрш орнууд болон “гуравдагч хөрш”-ийн хүрээнд тэнцвэртэй хөгжүүлэх замаар улс орныхоо аюулгүй байдлын баталгааг хангах нь зүйтэй юм.

Үүний тулд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилна” гэсэн Мэдлэгт суурилах зарчим, “Болзошгүй аюул, сорилтыг бодитой тодорхойлж, тэдгээрийг гэтлэн давахад хязгаарлагдмал нөөц, боломжийг үр дүнтэй дайчилна” гэсэн Бодитой хандах зарчим, “Даяаршил улс үндэстний бусдаас хамаарах эмзэг байдлыг нэмэгдүүлж, нөгөө талаас гадаад нөөц боломжийг ашиглан үндэсний ашиг сонирхлоо хамгаалж, бататгах боломж олгож байна” гэсэн Даяаршлын хүчин зүйлийг харгалзах зарчмуудыг удирдлага болгон, хурдтай хувьсан өөрчлөгдөж буй аюулгүй байдлын орчинд дүн шинжилгээ хийж, түүний үр дүнд тулгуурлан гарсан санал, зөвлөмжийг үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаанд ашиглах асуудал тулгамдаж байгаа нь энэхүү судалгааг явуулах хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Судалгааны ажлын зорилго:

Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчны мөн чанарын судалж, өнөөгийн байдлыг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон холбогдох

бусад бодлогын баримт бичгийн хүрээнд шинжлэн, аюулгүй байдалд нөлөөлж буй олон улсын геополитик, гадаад орчны нөлөөллийг тодорхойлж, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсруулахад оршино.

***Судалгааны ажлын зорилтууд*:**

1. Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчны мөн чанарыг судлах;
2. Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчны өнөөгийн байдлыг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон холбогдох бусад бодлогын баримт бичгийн хүрээнд шинжлэн, тулгамдаж буй ,асуудлуудыг тодорхойлох;
3. Монгол Улсын аюулгүй байдалд нөлөөлж буй геополитикийн нөхцөл байдал, гадаад орчны нөлөөллийг судлан тодорхойлох;
4. Судалгааны үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмжийг боловсруулах.

Судалгааны ажлын ач холбогдол:

Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчны өнөөгийн байдал, түүнд нөлөөлж буй геополитикийн нөхцөл байдалд шинжилгээ хийж, цаашид бодлого, эрх зүйн хүрээнд болон бодлогыг хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх санал, зөвлөмжийг боловсруулсанд оршино.

Судалгааны үр дүнд тулгуурлан гарсан санал, зөвлөмж нь практикт хэрэгжих бүрэн боломжтой юм.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАДААД ОРЧНЫ МӨН ЧАНАР

Аливаа улсын аюулгүй байдал нь гадаад орчин, дотоод байдал гэсэн хоёр хүчин зүйлийн нөлөөлөл дор бүрэлдэн бий болдог зүй тогтолтой бөгөөд үүний дотроос гадаад орчны нөлөөлөл нь тухайн улсыг хүрээлсэн орнуудын болон түүний өөрийнх ашиг сонирхол хоорондын харьцааны шинж чанараас үүсдэг.

Монгол Улсын хувьд үндэсний аюулгүй байдал нь олон улсын нөхцөл, нэн ялангуяа хоёр хөрш орны хүчний болон эрх ашгийн тэнцвэрт байдлаас ихээхэн хамаарч ирснийг түүх харуулдаг ба одоо ч энэ байдал үргэлжилсээр байна.[1]

Уламжлалт ойлголтоор улс гүрэн олон улсын тавцанд өөрийгөө гадаад бодлогоор дамжуулан илэрхийлдэг бөгөөд гадаад бодлогын үндэс нь үндэсний ашиг сонирхол байдаг. Гадаад бодлого нь хэзээд тухайн улсын хувьд нэн таатай олон улсын нөхцөл байдлыг буюу өөрөөр хэлбэл гадаад таатай орчныг бүрдүүлэхэд чиглэгдэж байдаг.[2] Мөн аливаа улс гадаад бодлогын шийдвэр гаргах бүрэн эрхээ алдахгүй байх нь тусгаар тогтнолоо хангах, бүрэн эрхээ хадгалах чухал шалгуур билээ.

Энэ өнцгөөс шинжилбэл Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нэн түрүүнд төрийн гадаад бодлого нэгдмэл байх, гадаад харилцаанд үндэсний ашиг сонирхлыг дээдлэх зарчмыг Үндэсний аюулгүй байдлыг хангах чухал арга зам гэж үзсэний зэрэгцээ улс төр, дипломатын үйл ажиллагааг үүнийг хангах үндсэн арга[3] гэж үзсэн нь бодлогын хувьд гадаад орчны хүчин зүйлсэд хандлагыг зохистой тодорхойлсныг илтгэж байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам” хэсэгт аюулгүй байдлын гадаад орчин, улсын гадаад бодлоготой холбоотой хэд хэдэн чухал заалтууд туссан байдаг.

Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчин манай улсын хэрэгжүүлэх гадаад бодлогоос гадна бусад нөлөө бүхий гүрнүүд, тэр дундаа Зүүн хойд Азийн гүрнүүдийн баримталж буй бодлого, үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай билээ.

---

[1]Д.Мягмар, Г.Сүхээ “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал: шинэ нөхцөл байдал, тодотгон шинэчлэх шаардлага”. Стратеги судлал. УБ., 2006/3, 6-7-р тал

[2]Г.Баасанхүү ба бусад- “Олон улсын харилцааны үндэс ба даяаршил” УБ, 2016, 98-р тал

[3] “Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал” 2010.07.15, 3.1.1-р заалт

Олон улсын харилцааны реалист дэг сургуульд олон улсын харилцаа, аюулгүй байдлын орчныг бүрдүүлэгч гол хүчин зүйлсийн нэг нь их гүрнүүдийн нөлөөгөө тэлэх, ашиг сонирхлоо хангах улс төр, геополитикийн бодлого, их гүрнүүдийн хоорондын харилцаа гэж үздэг.

Монгол Улс бол гадаад орчин дахь аливаа өөрчлөлтөд зохицох замаар ашиг сонирхлоо хамгаалах арга замыг эрэлхийлэхээс бус түүнд шууд нөлөө үзүүлж, олон улсын үйл явцыг эргүүлэх чадваргүй бүс нутгийн хамгийн пассив гишүүн юм.[4]

Олон улсын харилцаа, аюулгүй байдлын онолд бүрэн эрхт улсуудыг ялгах олон янзын ангилал байдаг. Үүнээс хамгийн өргөн тархсан нь өөрийн бүрэн эрхийг хангах боломжийн тэнцвэргүй байдлаас хамаарсан олон улсын ангилал юм. Өөрөөр хэлбэл, аюулгүй байдлаа хангах чадварын харилцан адилгүй боломж, түвшингээс хамааран улс гүрнүүд хоорондоо ялгаатай байдаг. Зарим улс зөвхөн өөрийн аюулгүй байдлыг хангах бүрэн дүүрэн хүчин чадалтай байгаад зогсохгүй хөрш орон, холбоотон цаашлаад бүс нутгийн аюулгүй байдлыг хангах хүчин чадалтай байдаг бол зарим улс бусдын тусламжтай аюулгүй байдлаа хангахаас өөр аргагүй байдалд оршдог.[5]

1.1. Гадаад бодлогын шийдвэр гаргалт

Монгол Улс аюулгүй байдлын гадаад таатай орчныг бүрдүүлэхийн тулд оновчтой, үндсэн зарчимд нийцсэн гадаад бодлого хэрэгжүүлэх, энэ чиглэлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох замаар аюулгүй байдлын орчинд нөлөөлөх гадаад хүчин зүйлсийн сөрөг нөлөөг аль болох бууруулах боломжтой юм.

Гадаад бодлогын шийдвэр гаргах 4 загвар бий[6]. Үүнд:

1. Рационал сонголт. Энэ загварын үед гадаад бодлогын шийдвэрийг төрийг эрх барьж буй нэг хүн гаргадаг.
2. Гадаад бодлогын шийдвэрийг нэг хүн бус, засгийн газрын нэгэнт тогтсон бүтэц зохион байгуулалт, эрх үүргийн дагуу гаргана.
3. Засгийн газрын эрх бүхий байгууллагуудын өөр хоорондын зөрчилтэй үзэл бодол, сонирхол дээр тулгуурлан, завсраас нь зөвшилцөл, наймааны хэлбэртэй шийдвэр гаргах.

[4] М.Батчимэг- “Шатрын өрөг дэх Монгол Улс” УБ, 2012. 163-р тал
[5] Г.Баасанхүү ба бусад- “Олон улсын харилцааны үндэс ба даяаршил” УБ, 2016, 75-р тал
[6] Г.Төмөрчулуун- “Даяар Ертөнц: Монголын геополитик, дипломат ажиллагаа”, Улаанбаатар., 2009 он, 37-р тал

4. Гадаад бодлогын шийдвэр гаргах ёстой асуудлыг хэд хэдэн хэсэг болгон хувааж, түүнээс аль чухлыг нь нь салган авч хэсэгчилсэн шийдвэр гаргах.

Бодит нөхцөл байдал дээр дээр дурдсан дөрвөн загварын аль нэг нь дангаараа тогтмол хэрэгжих нь ховор бөгөөд шийдвэр нь дөрвөн загварын хольц байдлаар гарах нь элбэг байдаг. Бодлогын шийдвэрт улс төрийн үйл явц болон бусад хүчин зүйлс нөлөөлдөг тул тогтмол нэг загвараар шийдвэр гаргах боломж хомс гэж үздэг.

Тэгэхдээ бага жижиг, ардчилсан улсууд ихэнх тохиолдолд хоёр дахь загвар буюу Засгийн газрын тогтсон зохион байгуулалтын дагуу шийдвэр гаргах нь илүү оновчтой, эрсдэл багатай байдаг.

Гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц өөрийн гэсэн шат дараалалтай байдаг. Үүнд мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, санал дүгнэлт гаргах, дээд байгууллагад шийдвэрийн төсөл боловсруулж өгөх, шийдвэр гаргах үе шат багтаж, гарсан шийдвэрийг практикт хэрэгжүүлснээр энэ үйл явц дуусгавар болдог.[7]

Ардчилсан улс орнуудын нийтлэг жишгийг харахад гадаад бодлогын санал, санаачлагыг хэн дэвшүүлэх, ямар албан тушаалтны хийсэн мэдэгдлийг төрийн бодлого гэж тооцох талаар нарийвчлан тусгадаггүй ч энэ чиглэлээр шийдвэр гаргах түвшинд тодорхой нэгдсэн ойлголт хэвшсэн байдаг.

Гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц тодорхойгүй, боловсронгуй бус байх нь төрийн гадаад бодлого нэгдмэл байх, гадаад харилцаанд үндэсний ашиг сонирхлыг дээдлэх зарчим алдагдах, гадаад бодлогын шийдвэр гаргахад субъектив хандлага нөлөөлөх эрсдлийг дагуулдаг.

1.2. Хөршийн харилцааны мөн чанар

Тухайн улс том жижгээсээ үл хамааран аливаа улсын аюулгүй байдлын гадаад орчин газар зүйн хүрээлэл буюу хөрш, зэргэлдээ улс орнууд, оршин буй бүс нутгаасаа хамгийн ихээр хамааралтай байдаг.

Тэр дундаа Монгол Улсын хувьд хоёр их гүрний дүнд байрлах, далайд гарцгүй орон тул хоёр хөрштэйгөө найрсаг харилцааг хөгжүүлэх нь гадаад бодлогын сонголт гэхээс илүүтэй шаардлага юм.

Зарим эрдэмтэд үндэсний ашиг сонирхлыг тухайн улсын газар зүйн байршилтай шууд холбоотой бодит өгөгдөл гэж үздэг. Өөрөөр хэлбэл, үндэсний ашиг сонирхлыг илэрхийлэх гол шалгуур нь геополитикийн хүчин зүйл байдаг.

[7] Г.Төмөрчулуун- “Монголын гадаад бодлого XX, XXI зууны зааг дээр” Улаанбаатар., 2016, 31-р тал

Тухайн улсын газар зүйн байршил, хүн амын тоо чанар, үндэстний түүхэн уламжлалт гэх мэт цаг хугацааны хувьд тогтвортой хүчин зүйлс үндэсний ашиг сонирхлыг тодорхойлдог байна.[8]

Аливаа их гүрнүүдийн харилцаа хурцдах тусам аль ч тал нь бага жижиг улс орнуудыг өөрийн талдаа татах, шууд нөгөөгийнхөө эсрэг ашиглах, сөргөлдөөндөө хүчээр татан оролцуулах оролдлого хийдэг. Тэр дундаа ОХУ, БНХАУ-ын харилцаа хурцдах нь энэ хоёр улсын дунд байрладаг Монгол Улсын хувьд сөргөлдөөнд татагдан орох эрсдэл маш өндөр болно. Монгол Улс хоёр хөршөөсөө аль алинаас нь тодорхой хэмжээнд хамааралтай болсон энэ цаг үед нэгтэй нь тогтоосон харилцаа хурцдах нь аюулгүй байдалд ноцтой аюул, занал болох эрсдэлтэй.

Нэн түрүүнд Монгол Улсын хувьд Орос, Хятад аль нь ч “Гуравдагч хөрш”-өөс илүү чухал гэдгийг санах нь зүйтэй. Тиймээс “Гуравдагч хөрш”-ийн бодлогыг явуулахын тулд нэн түрүүнд хоёр их хөршийнхөө хандлагыг ажиглах шаардлагатай юм.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ” хэмээсэн.

Аливаа улс орны хувьд аюулгүй байдалд нь хамгийн ихээр нөлөөлөх хүчин зүйл нь хөрш, зэргэлдээ улс орнууд билээ. Тэр дундаа жижиг улс орнуудын хувьд хөршийнхөө хэт хамааралд орох эрсдэл үргэлж оршсоор байдаг.

Монгол Улсын “Гуравдагч хөрш”-ийн бодлогын гол агуулга, зорилт нь хоёр хөршийнхөө нөлөөг хязгаарлахад оршиж байгаа ч энэ бодлого нь хоёр хөршийн эсрэг чиглэсэн бодлого огт биш юм.

Энэ хүрээнд аюулгүй байдал талаасаа Монгол Улс “Гуравдагч хөрш”-ийн бодлого хэрэгжүүлснээрээ *нэгд,* аюулгүй байдлаа хангахад дэмжлэг авах; *хоёрт,* ардчилсан засаглалаа дэмжүүлэх; *гуравт,* эдийн засгийн дэмжлэг, хөрөнгө оруулалт авах; *дөрөвт,* интеграцид оролцох чиглэлээр хамтран ажиллахыг эрмэлздэг.

Угаас Монгол Улсын гадаад бодлого, аюулгүй байдалтай холбоотой бүхий л баримт бичгүүдэд Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл нь хоёр их хөрш байхаар туссан.

[8] Г.Баасанхүү ба бусад- “Олон улсын харилцааны үндэс ба даяаршил” УБ, 2016, 111-р тал

Гадаад бодлогодоо хөрш орнуудтай харилцахыг тэргүүлэх чиглэл болгосноор газар зүйн детерминист онолд хальтран орж, өөрсдийгөө зөвхөн энэхүү үзэл бодлоор хүлж, бусад чиглэлийг идэвхгүй болгон дээрх тэргүүлэх чиглэлд захируулах байдал нэгэнт тогтжээ. Энэхүү гутрангуй хандлага улс орны хөгжлийг тодорхойлох хүчин зүйл болвоос Монгол дахин улс төрийн “дагуул” улс болох, эдийн засгийн хувьд “үйлчлэгч” болох, соёл, иргэншлийн хувьд тэнцвэржүүлэгч үүрэг гүйцэтгэж байсан Европын буюу Оросын соёлын нөлөө бүдгэрч тодорхойгүй болох төлөв бүрэлдэнэ.[9]

Монгол Улс гадаад бодлогоо хэрэгжүүлэхийн тулд баримталж буй голлох зарчим, чиглэл нь нэн түрүүнд хоёр хөрштэйгөө тэнцвэртэй харилцах, улмаар хоёр хөршийнхөө хэт нөлөөллөөс сэргийлэхийн тулд гуравдагч орнуудтай харилцах чиглэл юм.

Үүнээс гадна аливаа жижиг улс олон улсын хамтын нийгэмлэгийн идэвхтэй гишүүн байхын тулд олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, бүс нутгийн интергаци, хамтын ажиллагаанд нэгдэх шаардлага тулгардаг.

Даяаршил, интеграцийн үйл явц эрчимтэй явагдаж буйгаас аливаа улс аюулгүй байдлаа дангаар хангах боломжгүй болж байна. Тэр дундаа Монгол Улс шиг газар зүйн өвөрмөц байрлалтай, жижиг орны аюулгүй байдал оршин буй бүс нутгаасаа хамаарах нь дамжиггүй. Зөрчил, маргаан ихтэй, их гүрнүүдийн стратегийн зөрчлийн бүс болсон Зүүн хойд Азид аюулгүй байдлаа дангаар хангана гэдэг бүр хүнд асуудал хэдий ч Монгол Улс энэхүү бүс нутгийн орнуудтай бүгдтэй нь харилцаагаа хөгжүүлж, оновчтой гадаад бодлого явуулах замаар аюулгүй байдлаа хангахыг оролдсоор байна.

1.3. Хамтын аюулгүй байдлын тогтолцоо

Бүс нутгийн хамтын ажиллагааны тогтолцоо нь үндсэн хоёр хэлбэртэй байдаг нь хамтын аюулгүй байдлын болон хамтын батлан хамгаалах тогтолцоо юм.

Хамтын аюулгүй байдал хэмээх ойлголтын гол санаа нь аливаа улс өөрийн түрэмгийлэх, нөлөөгөө тогтоох ашиг сонирхлоо умартан олон улсын аюулгүй байдлыг хангахын тулд бусад улс оронтой хамтын ажиллагааг хөгжүүлж,

[9] Р.Болд- “Монголын Геополитикийн зарим асуудлууд” Улаанбаатар, 2019, 23-р тал

тэгснээрээ тухайн орнууд нийтээрээ нэг аюулгүй байдлын системийн доор өөрийнхөө болон бусдынхаа аюулгүй байдлыг хангах санаа юм.

Хамтын аюулгүй байдлын тухай ойлголтыг “хамтын батлан хамгаалах” гэсэн ойлголттой адилтган үзэж, хоорондынь хольж хутгах тохиолдлууд энэ чиглэлийн томоохон судлаачдын дунд ч байдаг.[10] Гэвч энэхүү хоёр ойлголт нь мөн чанартаа ялгаатай юм.

Хамтын батлан хамгаалахын тухай ойлголт нь нэг үзэл баримтлал бүхий улсууд тодорхой дайсны аюулын эсрэг нэгдсэн хүчээр батлан хамгаалах бүтэц юм. Энэ төрлийн бүтцийн хамгийн тод жишээ нь Хүйтэн дайны үеийн НАТО, Варшавын гэрээний эвслүүд байлаа. Энэхүү хоёр байгууллагын үйл ажиллагаа нь бие биенийхээ аюулаас сэргийлсэн хамтын батлан хамгаалах тогтолцооны шинж чанартай байсан.

Харин хамтын аюулгүй байдлын тогтолцоо нь хамтын батлан хамгаалах тогтолцоо шиг аль нэг тодорхой хүчний эсрэг чиглэдэггүй. Тогтолцооны гаднах орнуудын зүгээс учруулж болох аюул заналаас сэргийлэхээс гадна тогтолцоон дотроос учирч болох аюул заналаас сэргийлэхийг эрмэлздэг. Өөрөөр хэлбэл, тогтолцоонд нэгдсэн аль нэг улс түрэмгийлэхэд бусад нь нэгэн дуугаар эсэргүүцэх, тэгснээрээ ямар ч хүчирхэг гүрэн байсан түрэмгийлэх боломжгүйд хүргэх нь хамтын аюулгүй байдлын тогтолцооны гол зорилго юм. Үндсэндээ хамтын аюулгүй байдлын систем “нэг нь нийтийн эсрэг түрэмгийлвэл, нийт нь нэгийгээ зогсооно” гэсэн зарчим дээр суурилна.

Хамтын батлан хамгаалах тогтолцоонд нэг талыг барьсан холбоотон гүрнүүд нэгддэг байхад хамтын аюулгүй байдлын системд сөргөлдөгч гүрнүүд ч нэгдэн тогтолцооны хүрээнд нэгнээ хянах боломжтой.[11]

Энэхүү үзэл санаяны эх үндэс нь Вилсонизмийн үзэл санаа юм. АНУ-ын Ерөнхийлөгч асан Вудроу Вилсон 14 зүйл тунхагтаа “Олон улсын харилцааны систем хүчний тэнцвэр дээр бус харин ч угсаатны өөртөө засан тогтноход үндэслэх ёстой, улс орнуудын аюулгүй байдлын баталгаа нь цэргийн эвслүүд бус хамтын аюулгүй байдал байх ёстой.” хэмээсэн. [12]

[10] David H. Capie- “*The Asia Pacific Security Lexicon”* 2007. 56-р тал
[11] Мөн тэнд
[12] Хенри Киссинжер- “*Дипломат үйл ажил.*” Орчуулсан Д. Чулуундорж. УБ. 2012. 18-р тал.

Монгол Улсын хувьд гадаад бодлогын чиглэл, үндсэн зарчмыг нь авч үзвэл хамтын аюулгүй байдлын тогтолцоонд нэгдэх боломж нээлттэй бөгөөд хамтын батлан хамгаалах тогтолцоонд нэгдэх боломж хомс юм.

Мөн олон улсын харилцаанд сөргөлдөөн, зөрчил эргэн сэргэх магадлал өндөр байгаа энэ цаг үед хамтын батлан хамгаалах тогтолцоонд нэгдэх нь Монгол Улсад зарим түнш орнуудтай тогтоосон харилцаагаа золиослоход ч хүргэж болзошгүй юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАДААД ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгүүдэд аюулгүй байдлын гадаад орчны нөлөөллийг хэрхэн тодорхойлсныг өнөөгийн байдлын хүрээнд судаллаа.

2.1. Гадаад бодлогын үндсэн зарчим, шийдвэр гаргалт *(Үндсэн хуулийн 25.2-р зүйл, 33.1.4-р зүйл; УАБҮБ-ын 3.1.1.1, 3.1.1.2, 3.1.1.3-р заалт; Гадаад бодлогын үзэл бариmтлалын 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9 заалт, Батлан хамгаалах бодлогын үндсийн 1.1, 3.1 заалт)*

Монгол Улсын гадаад бодлого болон батлан хамгаалах бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодорхойлон заасан үндэсний ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд тус улсын гадаад, дотоод нөхцөл байдал нь гадаад бодлогын болон батлан хамгаалах бодлогын зорилго, зарчим, чиглэлийг тодорхойлох үндэс болдог[13],[14] байна.

Энэ хүрээнд нэн түрүүнд төрийн гадаад бодлого нэгдмэл байх, гадаад харилцаанд үндэсний ашиг сонирхлыг дээдлэх зарчмыг Үндэсний аюулгүй байдлыг хангах чухал арга зам гэж үзсэний зэрэгцээ улс төр, дипломатын үйл ажиллагааг үүнийг хангах үндсэн арга гэж үзжээ. [15]

Монгол Улсын гадаад бодлогын шийдвэр гаргах тогтолцоог харахад төрийн гадаад бодлого нэгдмэл байх зарчим үндсэндээ хэрэгжиж байгаа ч зарим хуулийн заалт хоёрдмол утгатай эсвэл урвуулан ашиглах боломжтой байгаагаас үүдэн энэ зарчим алдагдах эрсдэл учирч байна.

Монгол Улсын Үндсэн хуульд “төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох”[16]-ыг УИХ-ын онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэхээр, “гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлөх”[17]-ийг Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхэд хамаарахаар тусгасан байдаг.

Энэ заалтаас үүдэн олон улсад Монгол Улсын гадаад бодлогын талаар ташаа ойлголт түгсэн бодит жишээ өнгөрсөн хугацаанд гарсан.

---

[13] “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”-ын 1 дэх заалт
[14] Батлан хамгаалах бодллогын үндэс” баримт бичгийн 1.1. дэх заалт
[15] “Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал” 2010.07.15, 3.1.1-р заалт
[16] “Монгол Улсын Үндсэн хууль” 1992.01.13, 25.2-р зүйл
[17] “Монгол Улсын Үндсэн хууль” 1992.01.13, 33.1.4-р зүйл

2015 онд Монгол Улсын Ерөнхийлөгч ҮАБЗ-ийн Зөвлөмжийг үндэслэн, бүрэн эрхийнхээ хүрээнд “Байнга төвийг сахих тухай” санаачилга гаргаж, түүнийгээ НҮБ-ын индэр дээрээс зарласан[18] нь дотоод улс төрийн хүрээнд маргаан дагуулаад зогсохгүй, олон улсын тавцанд ташаа ойлголт түгэхэд хүргэсэн.

Ерөнхийлөгч гадаад бодлогын санаачилга гаргасан нь “гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлөх” бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлсэн алхам байж болох ч “төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох” бүрэн эрх бүхий байгууллага буюу УИХ-аар хэлэлцэн шийдээгүй асуудлыг олон улсын тавцанд хөндөн тавьсан нь зохистой алхам байсан эсэх нь эргэлзээтэй.

Ерөнхийлөгч санаачилга гаргасныхаа дараагаар бүрэн эрхийнхээ хүрээнд “Төвийг сахих тухай” хууль санаачилж өргөн барьснаас жил гаруйн дараа УИХ хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэнээр[19] Ерөнхийлөгчийн санаачилга бодлого болж чадаагүй төдийгүй бүтэн жил гаруйн туршид шийдвэр гаргах түвшинд болон эрдэмтэн, судлаачдын дунд энэ асуудлаар маргаан дэгдэхэд хүргэсэн.

Эндээс үүдэн зарим судлаачид гадаад бодлоготой холбоотой эрх мэдлийн хуваарилалт, гадаад бодлогын санаачилга дэвшүүлэхэд баримтлах зарчмыг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж буйгаа илэрхийлэх болсон.

Ерөнхийлөгч эрх зүйн талаасаа хуулийн төсөл санаачлан өргөн барих бүрэн эрхтэй[20] тул гадаад бодлоготой холбогдох тодорхой асуудлаар хууль санаачилж болох ч төрийн эрх барих дээд байгууллага болох УИХ хуулийн төслийг хэлэлцэн батлахаас өмнө олон улсын тавцанд санаачилгаа зарлан тунхаглах нь зохистой эсэх асуудал зайлшгүй хөндөгдөж байна.

Монгол Улсын Үндсэн хуулинд Ерөнхийлөгч “Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах”[21] бүрэн эрхтэй байхаар тусгасны нэгэн адилаар Ерөнхийлөгч олон улсын тавцанд гадаад бодлогын санаачилга дэвшүүлэхдээ ч өмнө нь УИХ-тай зөвшилцөх эрх зүйн зохицуулалттай болох нь зүйтэй ч байж болох талтай.

Дээр дурдсан жишээтэй холбоотойгоор Монгол Улсын гадаад бодлогын шийдвэр гаргах тогтолцоо боловсронгуй байх тухай асуудал зайлшгүй хөндөгдөх юм. Гадаад бодлогын шийдвэр гаргах тогтолцоо боловсронгуй байх нь Монгол

[18] Э.Уранцэцэг- “Төвийг сахих Монгол” 2015.10.21 https://news.mn/r/707478/
[19] Байнга төвийг сахих хуулийг санаачлагчид нь буцаав. https://montsame.gov.mn/mn/read/38373. 2016.11.17
[20] “Монгол Улсын Үндсэн хууль” 1992.01.13, 26.1-р зүйл
[21] “Монгол Улсын Үндсэн хууль” 1992.01.13, 33.1.4-р зүйл

Улсын гадаад бодлого оновчтой, үр дүнтэй хэрэгжих нөхцлийг бүрдүүлж, цаашлаад Монгол Улсын аюулгүй байдлын гадаад таатай орчныг бий болгоход нөлөөлнө гэж үзэх үндэстэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу тус улсын гадаад бодлогын асуудлуудаар шийдвэр гаргахад Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар гурвуулаа оролцож байна. Чингэхдээ гадаад бодлогын ерөнхий чиг шугамыг Улсын Их Хурал тодорхойлж, Засгийн газар хэрэгжүүлж байхаар тогтоосон. Үүний зэрэгцээ гадаад бодлогын зарим тодорхой асуудлыг Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамааруулсан буй. Ерөнхийлөгчийн тэргүүлдэг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл гадаад бодлогод чухал үүрэгтэй байх нь мэдээж.[22] Тэгэхдээ ийм тогтолцоо Монгол Улсад шинээр бүрэлдэн хөгжиж буй тул гадаад бодлогын чухам ямар хүрээний асуудлыг хэн нь шийдэж, шийдвэр гаргах талаар нэгдсэн ойлголт хэвшээгүйн нэг илрэл нь төвийг сахих санаачлагыг тойрсон үйл явц байсан гэж үзэх үндэс бий.

Гадаад бодлогын шийдвэр гаргахад юуны өмнө мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, санал дүгнэлт гаргах, дээд байгууллагад шийдвэр гаргах төсөл боловсруулж өгөх, шийдвэр гаргах, шийдвэрийг практикт хэрэгжүүлэх гэсэн үе шатыг дамждаг.

Харин төвийг сахих тухай санаачилгад дэвшүүлэхэд энэхүү шат дараалал мөрдөгдөөгүй гэж үзэх үндэстэй бөгөөд цаашид ч энэ мэтээр шийдвэр гаргах шат дарааллыг зөрчиж, шйдвэр гарах эрсдэл оршсоор байна.

Энэ зарчмын хүрээнд Монгол Улсад 2013 онд “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай” Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 01/01 дүгээр зөвлөмжид үндэслэн Монгол Улсын Засгийн газар “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам”-ыг баталсан.

Энэхүү журам “Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Гадаад харилцааны асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн Монгол Улсын гадаад бодлого, олон улсын харилцааны тодорхой асуудлаар мэдэгдэл хийнэ”[23], “Олон болон хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны талаарх байр суурийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Шадар сайд, тухайн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн болон Элчин сайд илэрхийлнэ”[24] хэмээн тусгаснаас үзэхэд Ерөнхийлөгчийн хийсэн мэдэгдлийг улсын албан ёсны байр суурь гэж үзэх

[22] Мөн тэнд, 45-р тал
[23] “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам” Монгол Улсын Засгийн газрын 169 дүгээр тогтоол., 2013.05.16, 2.3-р заалт
[24] Мөн тэнд 2.4-р заалт

үндэстэй. Гэвч Ерөнхийлөгч УИХ-аар тодорхойлоогүй бодлогын асуудлаар байр сууриа илэрхийлэх нь зохистой эсэх асуудлаар тодорхой заалт тусаагүй байна.

Гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц тодорхойгүй, боловсронгуй бус байх нь төрийн гадаад бодлого нэгдмэл байх, гадаад харилцаанд үндэсний ашиг сонирхлыг дээдлэх зарчим алдагдах, гадаад бодлогын шийдвэр гаргахад субъектив хандлага нөлөөлөх эрсдэлийг дагуулдаг.

Энд байнга төвийг сахих санаачилга дэвшүүлсэн үйл явцыг жишээлэн авч үзсэн нь тухайн санаачилга зөв эсвэл буруу байсан эсэх асуудлыг хөндөж буй зүйл биш бөгөөд харин гадаад бодлогын шийдвэр гаргах тогтолцооны талаас нь авч үзвэл зайлшгүй анхаарал татах жишээ мөн болохыг цохон тэмдэглэж байна.

Түүнчлэн Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Монгол Улс “энхийг эрхэмлэсэн гадаад бодлогоо тууштай баримталж, энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагааг идэвхтэй дэмжинэ”[25] хэмээн тусгасан.

Дээрх заалтын хүрээнд Монгол Улс өнгөрсөн хугацаанд олон улсын ямар нэг зэвсэгт мөргөлдөөн, улс хоорондын маргаанд нэг талыг дэмжээгүй, зөрчилдөөнтэй асуудлуудаар төвийг сахисан байр суурь баримталсаар ирсэн.

Өнгөрсөн он жилүүдэд олон улсын харилцаанд маргаан дэгдээж, олон улсын хамтын нийгэмлэгээр хэлэлцсэн “Орос, Украйны нөхцөл байдал”, “БНХАУ Шиньжаан Уйгурын бүсэд хүний эрхийг ноцтой зөрчсөн эсэх”, “АНУ Иерусалим хотыг Израйлийн нийслэл болохыг хүлээн зөвшөөрч, ЭСЯ-аа тус хотод нүүлгэх шийдвэр гаргасан” зэрэг асуудлыг хэлэлцэхэд түтгэлзсэн санал өгсөн нь Монгол Улсын гадаад бодлогын зарчим, чиглэлтэй шууд нийцсэн шийдвэр гэж үзэх үндэс бий.

2.2. Хоёр хөршийн харилцааны өнөөгийн байдал *(Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.1.4; Гадаад бодлогын үзэл баримтлалын 14.1 заалт)*

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Чингэхдээ үндэсний эрх ашиг, харилцааны түүхэн уламжлалыг харгалзан бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг эрхэмлэж, бүхэлдээ тэнцвэртэй

[25] “Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал” 2010.07.15, 3.1.1.3-р заалт

харилцахыг эрмэлзэнэ”[26]. Гадаад бодлогын үзэл баримтлалд “ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзана[27] хэмээсэн бөгөөд Монгол Улс БНХАУ-тай 2014 оноос, ОХУ-тай 2019 оноос иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлж байна.

Түншлэлийн харилцааны түвшин, шатлал, ач холбогдлыг олон улсад харилцан адилгүйгээр ойлгох хандлага байна. Хэдий тийм ч Монгол Улсын талаас бусад улс орнуудтай тогтоосон харилцааг түншлэл талаас нь авч үзвэл дараах ангилал харагдаж байна.

1. Иж бүрэн стратегийн түншлэл (БНХАУ, ОХУ)
2. Стратегийн түншлэл (Япон, Энэтхэг, АНУ)
3. Иж бүрэн түншлэл (Турк, БНСУ)
4. Өргөн хүрээтэй түншлэл (ЕХ-ны зарим орнууд, Австрали)

Монгол Улсын ОХУ, БНХАУ-тай тогтоосон түншлэлийн түвшин 2019 онд ижил түвшинд хүрсэн нь хоёр хөрштэйгөө бүхэлдээ тэнцвэртэй харьцах зарчимд нийцсэн алхам мөн. Гэвч Монгол Улс 2011 онд ОХУ-аас өмнө Япон Улстай стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон нь бодлогын ерөнхий чиглэлээс зөрсөн зүйл болсон гэх шүүмжлэл тухайн үедээ гарч байсан.

Өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл буюу хоёр хөршийн хоорондын харилцаа маш хурдацтайгаар сайжирсан.

Энэ нь нэг талаасаа хоёр улс аль аль нь олон улсын харилцаа, одоо тогтсон дэг журмыг өөрчилж, олон туйлт системийфг тогтоохыг эрмэлзэж байгаатай, нөгөө талаасаа ОХУ нь Украйны асуудлаас үүдэн Европын холбоотой, БНХАУ нь тодорхой асуудлуудаас үүдэн АНУ-тай зөрчилдөж эхэлсэнтэй холбоотой гэж үзэх үндэстэй юм.

ОХУ-ын хувьд эрчим хүчний нөөц, түүхий эдийн голлох нийлүүлэгч орны хувьд эдийн засаг нь түүхий эдийн экспортоос шууд хамааралтай байдаг. Гэтэл Европын Холбооноос ОХУ-ын эсрэг хориг тавьснаас үүдэн тус улс эрчим хүчний

[26] “Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал” 2010.07.15, 3.1.1.4-р заалт
[27] “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”.2011 он. 14.1 заалт

чухал хэрэглэгч зах зээл буюу БНХАУ болон Азийн бусад орнууд руу түүхий эд их хэмжээгээр нийлүүлэхээс аргагүй болсон.

Энэ нь нэг талаасаа хоёр талын бараа эргэлтийг нэмэгдүүлж, нөгөө талаасаа бусад салбарын харилцаа ойртон нягтрахад хүргэсэн.

ОХУ, БНХАУ-ын найрсаг, ойр дотно харилцаа тодорхой хугацааг хамарсан нийтлэг зорилт, ашиг сонирхол дээр тулгуурласан тул үргэлжлэх хугацаа нь тодорхойгүй гэх таамаг олон улсын харилцааны голлох эрдэмтдийн дунд зонхилж байна. Хоёр хөршийн харилцааны хэв шинж өөрчлөгдөх тутамд Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчинд өөрчлөлт гарна.

Өнгөрсөн зуун жилийн хугацаанд умард хөрш Монголыг буфер байлгах, холбоотон болгох, стратегийн хувьд түншлэх, харин өмнөд хөрш Монголыг үл зөвшөөрөх, найрамдалт харилцаатай байх, стратегийн түнш байлгах гэсэн тус тусын чиг бодлогыг явуулж иржээ. Буфер улс гэдгийг улс төрийн газар зүйн үүднээс хоёр буюу түүнээс дээш хоорондоо дайсагнасан улсын дунд оршиж, тэгснээрээ тэдгээрийн хоорондын хилийн мөргөлдөөнийг багасгадаг бие даасан жижиг улсыг хэлнэ гэж тодорхойлсон байдаг. [28]

Дээр дурдсанаар хөршүүдийн харилцаа дайтах хүртлээ муудахгүй бол тэдгээрийн дунд буфер улсын ач холбогдол нэг их биш. Энэ нөхцөлд тэдгээрийн хоорондын далдуур өрсөлдөөнд дундаж байр суурьтай байж, хязгаарлагдмал төвийг сахих хэрэгтэй бөгөөд харин бусад чиглэлд туйлын идэвхтэй бодлого явуулах шаардлагатай. Орос, Хятадын стратегийн түншлэл нь өөрсдийнх нь хэлдэгээр цэргийн холбоотны харилцаа биш, гуравдагч этгээдийн эсрэг чиглээгүй боловч АНУ, өрнөдийн давуу байдлыг саармагжуулан хүчний тэнцвэрийг сэргээх зорилготой.[29]

ОХУ, БНХАУ-ын харилцаа ойрын ирээдүйд одоо байгаа шинж байдлаа хадгалах буюу цэргийн холбоотон болохгүй ч улам ойр харилцаж, нягтрах төлөвтэй байна. Дээр дурдсанчлан энэ нөхцөлд Монгол Улс заавал хэн нэгний буферийн үүрэг гүйцэтгэх шаардлагагүйн дээр хоёр улсын хооронд шууд зөрчил үүсэхгүй бол нэгийнх нь эсрэг нөгөөтэй нь эвсэх, аль нэгийг нь сонгох тулган шаардалтад өртөхгүй юм.

[28] “The Harper Dictionary of Modern Thought” Edited by Allan Bullock and Oliver Stallybass 1977, p.604 (дам ишлэв)
[29] Р.Болд- “Монголын Геополитикийн зарим асуудлууд” Улаанбаатар, 2019, 22-р тал

Тиймээс Монгол Улсад хоёр хөрштэйгөө нэгэн зэрэг түншлэлийн харилцааг хөгжүүлж, тэнцвэртэй хамтран ажиллах боломж бүрдэнэ.

Түүнчлэн энэхүү таатай нөхцөл, боломжийг ашиглан Монгол Улсын талаас хоёр хөрштэйгөө гурван талт уулзалт зохион байгуулах санаачилга гаргасан нь амжилттай хэрэгжиж байгаагийн зэрэгцээ салбар хоорондын уулзалтууд зохион байгуулагдаж, гурван талт хамтын ажиллагаа идэвхтэй хөгжиж байна.

Сүүлийн жилүүдэд олон улсын харилцааны практикт гурван талт механизмаар асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэх арга хүчтэй нэвтрээд байна. Олон улсын болон бүс нутгийн хэмжээнд гурван талт хамтын ажиллагаагаар шийдвэл зохих асуудлууд оршсоор байгаа тул улс орнууд ийм төрлийн хамтын ажиллагааны тогтолцоо бүрдүүлэхийг хичээх боллоо.

Гурван улсын өөр хоорондоо байгуулсан стратегийн түншлэлийн гэрээ, хэлэлцээрүүд нь гурван талт харилцааг хөгжүүлэх гол үндэс болж буй бөгөөд хоёр хөрштэйгөө тогтоосон хоёр талт харилцааг хөгжүүлэх нь гурван талт хүрээнд хөндөгдөх асуудлын цар хүрээг тэлэх боломжийг бүрдүүлнэ. Тиймээс 2019 оноос хоёр хөрштэйгөө аль алинтай нь иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд харилцаж эхэлснээр гурван талт яриа хэлэлцээ ч өргөжих таатай нөхцөл болж байна.

Монгол Улсын хувьд хоёр хөрштэй тогтоосон хоёр талт болон гурван талт харилцаа, хөрш орнуудын хоорондын харилцаа сайн байх нь тодорхой сорилтын зэрэгцээ, тодорхой боломжийг үүсгэж байгаа.

Нэн түрүүнд гурван улс хамтран дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх асуудал гурван талт харилцааны хүрээнд тогтмол хөндөгдсөөр ирсэн.

Гурван талын хамтын ажиллагааны үр дүнд Монгол Улсад гарч буй хамгийн томоохон боломж нь хоёр улсын хоорондын бараа эргэлт, түүхий эдийн дамжин өнгөрөх бүс болох боломж юм.

Тэр дундаа хоёр улсыг холбосон байгалийн хийн хоолойг Монголын нутгаар дайруулах асуудлаар ахиц гарч буйг ОХУ болон Монгол Улсын талаас мэдэгдэж, тодорхой шийдвэрүүд гарч байна.

Цаашдаа төсөл бодитоор хэрэгжлээ гэж үзэхэд дамжин өнгөрөх тээвэртэй холбоотой гэрээ, хэлэлцээг Монгол Улс өөрт ашигтай байдлаар байгуулахаар хэлэлцээ хийх шаардлага тулгарна.

Товчхондоо Монгол Улс гэрээг ашигтай нөхцлөөр байгуулж байж байгалийн хийн хоолойн бодит үр өгөөжийг хүртэх боломж бүрдэнэ. Харин нийгэмд эргэлзээ

дагуулсан байдлаар, ашиггүй нөхцлөөр гэрээг байгуулвал энэ гэрээ урьд өмнө нь гаднын улс орнуудын томоохон аж ахуй нэгжүүдтэй байгуулсан гэрээ, хэлэлцээрүүдийн нэгэн адил нийгэмд эргэлзээ төрүүлсэн, хагарал үүсгэж болохуйц сэдэв ч болох эрсдэл бий.

Монгол Улс хоёр хөрштэйгөө гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, тэр хүрээндээ дэд бүтэц болон бусад салбарын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд тодорхой механизмыг бүрдүүлэх шаардлагатай. Үүнд дотоод, гадаадын гэсэн хоёр механизм байж болохыг эрдэмтэд санал болгосон байна.

1. Дотоод механизм. Гурван талт хамтын ажиллагааг хариуцсан Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга /дэд сайд/-аар ахлуулсан дотоодын ажлын хэсэг энэхүү үзэл баримтлалын төсөлд дурьдсан салбаруудыг хариуцсан яамдын холбогдох албан тушаалтнуудыг оролцуулсан ажлын хэсгүүд байгуулж, гурван талт хамтын ажиллагааны гадаад механизмд зориулсан санал боловсруулах чиг үүрэгтэй байна.
2. Гадаад механизм. Энэ механизм гурван улсын Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга /дэд сайд/ нарын уулзалтыг хэлж байгаа юм. Манай тал дотоод механизмаас санал болгосон хамтын ажиллагааны салбаруудын тухай саналаа гурван улсын Гадаад хэргийн сайд нарын уулзалтын үеэр дэвшүүлж санал солилцон шийдвэр гаргуулж, асуудлыг улмаар дээд хэмжээний уулзалтаар ярих асуудлын жагсаалтад оролцуулж хэлэлцүүлэх замаар явагдана.
3. Дээд хэмжээний уулзалтаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлыг мөнөөх дотоод ажлын хэсэг хариуцна. Энэ ажлын хэсэг дээрх шийдвэрийг хэрэгжүүлэх талаар ажлын хэсгээс хийсэн ажлын тухай мэдээллийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Гадаад хариллцааны яамны удирдлагад байнга мэдээлж байна.[30]

Хоёр хөрш өөр хоорондоо сөргөлдөх магадлал эрс буурснаар Монгол Улс нэгийнх нь эсрэг дайн, зөрчилд татагдан орох эрсдэл эрс буурч байгаа юм. Ингэснээр Гадаад бодлогын үзэл баримтлал болон Батлан хамгаалах бодлогын үндэст заасан “гадны цэргийн аюул занал учраагүй нөхцөлд цэргийн аливаа холбоонд нэгдэхгүй, нутаг дэвсгэр, агаар мандлаа аль нэг улсын эсрэг ашиглуулахгүй байх, гадаадын цэргийн хүчнийг өөрийн нутаг дэвсгэрт

[30] Г.Төмөрчулуун- “Монголын гадаад бодлого XX, XXI зууны зааг дээр” Улаанбаатар., 2016, 81-р тал,

нэвтрүүлэхгүй, байрлуулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй байх чиг шугам баримтална."[31] бодлогоо тогтвортой хэрэгжүүлэх бодит боломж нэмэгдэж байна.

Түүхэн туршлагаас харахад 1960-1980-аад онд хоёр хөршийн харилцаа түүхэнд байгаагүй хурцдах үед Монгол Улс нэгийнх нь цэргийг газар нутагтаа байрлуулж, нөгөөтэй нь шууд зөрчилдөж байсан бөгөөд нөхцөл байдал илүү хурцадсан бол дайны талбар болох эрсдэлтэй нөхцөлд байсан.

Онолын талаас асуудлыг авч үзвэл аливаа их гүрнүүдийн харилцаа хурцдах тусам аль аль тал нь бага жижиг улс орнуудыг өөрийн талдаа татах, шууд нөгөөгийнхөө эсрэг ашиглах, сөргөлдөөндөө хүчээр татан оролцуулах оролдлого хийдэг. Тэр дундаа ОХУ, БНХАУ-ын харилцаа хурцдах нь энэ хоёр улсын дунд байрладаг Монгол Улс сөргөлдөөнд татагдан орох эрсдэл маш өндөр болно. Монгол Улс хоёр хөршөөсөө аль алинаас нь тодорхой хэмжээнд хамааралтай болсон энэ цаг үед нэгэнтэй нь тогтоосон харилцаа хурцдах нь аюулгүй байдалд ноцтой аюул, занал болох эрсдэлтэй.

Монгол Улсын хоёр хөрштэй тогтоосон харилцааны хүрээнд зайлшгүй хөндөгддөг асуудал нь үзэл баримтлалууд дээр тусгасны дагуу "түүхэн уламжлалыг харгалзан" "бүхэлдээ тэнцвэртэй харилцах" зарчмууд хэрэгжиж байгаа эсэх асуудал билээ.

Тэр дундаа эдийн засгийн салбарт Монгол Улс, ОХУ-ын бараа эргэлт маш бага байгаа, тэр дундаа Монгол Улсаас ОХУ руу чиглэсэн экспорт нь импортоос бараг 20 дахин бага байгаа нь нэн түрүүнд хоёр талын худалдааны тэнцвэр, нөгөө талаасаа Монгол Улсын экспортын тэнцвэрийн хувьд голлох асуудал болж байна

Мөн Монгол Улс БНХАУ руу гаргадаг экспортоос хамааралт байдлаар дэлхийд тэргүүлж байна.

Тоо баримтаас харахад Монгол Улсын экспортын 85.6 хувийг БНХАУ бүрдүүлж байхад ОХУ ердөө 1.1 хувийг бүрдүүлдэг.[32]

Олон улсын томоохон шинжээчид БНХАУ-ын өрийн занга гэх нэр томъёог ашиглаж, БНХАУ нь улс орнуудыг эдийн засгийн хувьд хараат болгох замаар өөрт ашигтай улс төрийн шийдвэр гаргуулж байна гэж дүгнэх нь нэмэгдэж буй нь ч анхаарах асуудал болж байна.

Тиймээс Монгол Улс ОХУ руу чиглэсэн экспортын урсгалаа нэмэгдүүлэх чиглэлд анхаарах нь эдийн засгийн гэхээсээ илүү аюулгүй байдлын асуудал

[31] Гадаад бодлогын үзэл баримтлал. 2011., 11-р заалт
[32] Монгол Улсын Үндэсний статистикийн хороо

болоод байна. Гэтэл хоёр талын хооронд худалдаалагдах бараа бүтээгдэхүүний төрөл, хэмжээ хязгаарлагдмал байгаа, ОХУ-ын Монгол Улстай хил залгаа бүс эдийн засгийн чадавх сул, иргэд нь худалдан авах чадвар багатай байгаа нь нөхцөл байдлыг улам хүндрүүлж байна.

2.3. "Гуравдагч хөрш"-ийн харилцааны өнөөгийн байдал *(Үндэсний аюулгүй байдлын үзэл бариимтлалын 3.1.1.5; Гадаад бодлогын үзэл бариимтлалын 14.2 заалт)*

Үзэл баримтлалд "Гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ" хэмээсэн.

Монгол Улсын "Гуравдагч хөрш"-ийн бодлогын гол агуулга, зорилт нь хоёр хөршийнхөө нөлөөг хязгаарлахад оршиж байгаа. Гэхдээ "гуравдагч хөрш"ийн бодлогыг хэрэгжүүлэхдээ хоёр хөршийнхөө хандлага, нөлөөг тандах нь зайлшгүй.

Монгол Улсын "Гуравдагч хөрш"-ийн бодлого Монгол Улсын газар зүйн нөхцөл байдал, аюулгүй байдлын гадаад орчноос шууд хамааралтай тул мөнхийн шинж чанартай бодлого боловч хоёр хөрштэй холбоотой болон бусад хүчин зүйлсээс хамааран энэхүү бодлогод эрчимжих, саармагжих үе байхыг үгүйсгэхгүй.

"Гуравдагч хөрш"-ийн бодлого "зөөлөн тэнцвэржүүлэх" замаар хэрэгжинэ гэж үзвэл "зөөлөн тэнцвэржүүлэх" бодлогын үндсэн нөхцөлөөр "Гуравдагч хөрш"-ийн бодлогын хязгаарыг (limitation) тодорхойлж болохоор байна. [33] Энэхүү хязгаарыг дараах байдлаар тоймлон тайлбарлах боломжтой юм.

1. Хоёр хөрш манай оронд довтлох ноцтой аюул занал байхгүй байх.
2. Хөрш их гүрнүүд манай орны аюулгүй байдлын гол баталгаа, гадаад бодлогын тэргүүлэх чиглэл хэвээр байх.
3. "Гуравдагч хөрш"-ийн зүгээс Орос, Хятадыг тэнцвэржүүлэх хазаарлах бодлого явуулаагүй байх.

Дээрх гурван асуудлыг Монгол Улсын "Гуравдагч хөрш"-ийн бодлогын гурван хязгаар гэж үзжээ. Эдгээр гурван хүчин зүйл хангагдахаа болих юм бол Монгол Улсын "Гуравдагч хөрш"-ийн бодлогод аюул учрах юм.

[33]О.Машбат- "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын баримтлал ба гуравдагч хөршийн бодлогын хязгаар""Их гүрнүүдийн хүрээлэлд орших улсын бодлого: Монгол Улсын "Гуравдагч хөрш"-ийн бодлого" эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. УБ. 2011.

Дээр дурдсан гурван хүчин зүйлийн хангагдаж буй байдлаас шалтгаалан Монгол Улсын “Гуравдагч хөрш”-ийн бодлого зарим үед эрчимжиж, зарим үед саармагжих нь гарцаагүй ч ерөнхий бодлого мөнхийн хэв шинжтэй.

Гэвч энэхүү бодлогыг шүүмжлэх, зарим талаар буруушаах хандлага гарч буйг ч цаашдаа харгалзан үзэх зайлшгүй шаардлага байгаа бөгөөд бодлогыг зарим талаар нэгтгэн дүгнэх, зарим талаар онолын үндэслэлтэй болгох шаардлага байна.

“Гуравдагч хөрш”-ийн бодлоготой холбоотойгоор зайлшгүй хөндөгдөх асуудал нь “Гуравдагч хөрш” орнуудын Монгол Улс дахь ашиг сонирхол юм. Монгол Улсын хувьд “Гуравдагч хөрш”-үүд чухал ач холбогдолтой байгаагийн нэгэн адилаар Монгол Улсад тэдгээр орнуудын ашиг сонирхол, ямар нэг хэлхээ холбоо байх ёстой. Хэрвээ тухайн улсын бодит ашиг сонирхол Монгол Улсад байхгүй бол хоёр талт харилцаа бодит байдал дээр хөгжих боломж багасч “Гуравдагч хөрш”-ийн бодлого хоосон лоозогносон шинж чанартай болох юм.

Хоёр орны сонирхол, манай өөрийн үндэсний сонирхол болон нөгөө талын ашиг сонирхол нийлж байж дипломат харилцаа явах ёстой.[34]

“Гуравдагч хөрш”-ийн бодлогыг хамтын үнэт зүйлс дээр суурилсан гэсэн ойлголт бий. Хамтын үнэт зүйлс гэдэгт ардчилал, хүний эрхийг дээдлэх зарчим, чөлөөт зах зээл зэргийг хамаатуулж ойлгож болно. Хоёр талт харилцааг хөгжүүлэхэд хамтын үнэт зүйлсээс ч илүү анхаарууштай зүйл нь харилцан эрх ашиг юм.

Саяхныг хүртэл “Гуравдагч хөршийн үзэл баримтлал”-ын дагуу сонгосон гол орнууд нь АНУ, Япон, БНСУ, Европын холбоо байж, улс төрийн харилцааны хүрээнд тодорхой ахиц, амжилт олж ирсэн хэдий ч тэдгээр улсуудын хувьд Монгол улс дахь бодит сонирхол хараахан бүрдээгүй байсан гэж хэлж болохоор байна. Харин сүүлийн жилүүдэд манай улсын уул уурхайн баялгийн нөөц тогтоогдож, зарим ордыг ашиглах төсөл хэрэгжиж эхлэх болсноор манай улсыг “гуравдагч хөрш”-өө болгохыг сонирхсон олон улс орон бий болсон нь энэхүү үзэл санаа хэрэгжих түүхэн шинэ нөхцөл бүрдэж байна.

Эдгээрээс харахад Монгол Улс “Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд Өрнө, Дорны голлох ардчилсан орнуудтай тогтоосон түншлэлийн шинэ харилцаа нь дараах үндсэн шинж чанарыг агуулж байгаа нь ойлгогдож байгаа юм. Үүнд:

[34]И. Очирбал- Монгол Улсын гадаад бодлогын анхны үзэл баримтлал батлагдсаны 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал дээр хэлсэн үг.” УБ. 2014.

- Хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлс, ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцаа, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдэлсэн;
- Хоёр улсын төр, засаг харилцааг иж бүрэн хөгжүүлэх эрмэлзэл төгс; (тухайлбал газар нутаг, өр авлагын маргаангүй, олон улсын терроризм, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, цөмийн зэсгийг үл дэлгэрүүлэх болон пуужингийн хамгаалах хөтөлбөр зэргийн талаар ижил байр суурьтай);
- Талуудын харилцаа нь улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, соёл боловсрол, байгаль хамгаалал, хүмүүнлэг, батлан хамгаалах, аюулгүй байдлыг бүрэн хамарсан буюу хамрах төлөв байдалтай;
- Хоёр талийн эдийн засгийн бүтэц нь харилцан бие биенээ нөхөх боломжтой;
- Бизнесийн хүрээнийхэн, төрийн бус байгууллага, иргэд хоорондын харилцааны түвшин идэвхтэй хөгжиж байгаа;
- Хоёр улсын ард түмний бие биенээ харьцангуй өндөр түвшинд танин мэдсэн;
- Олон тулгуурт, нээлттэй, бие даасан, үндэсний эрх ашигт нийцсэн гадаад, дотоод бодлого явуулдаг, түүнийгээ харилцан хүндэтгэсэн;
- Бүс нутгийн болон олон улсын харилцааны асуудлаар ижил буюу төстэй байр суурь баримталдаг;
- Бүс нутгийн болон олон улсын байгууллагад бие биеэ харилцан дэмжсэн зэрэг олон хүчин зүйлүүдийг оруулж болох юм.[35]

“Гуравдагч хөрш”-ийн бодлогыг шүүмжлэх, буруушаах хандлага нийгэмд болон судлаачдын дунд байдаг. Нэн түрүүнд энэхүү бодлого Монгол Улсын хоёр хөрштэйгөө харилцах харилцаанд сэв суулгаж байна гэсэн шүүмжлэл гардаг.

Өнөөгийн олон улсын харилцаанд үүсээд буй нөхцөл байдлыг харахад Монгол Улсын хоёр хөрш, “гуравдагч хөрш”-үүдийн харилцаанд зарим талаар маргаантай байна. “Гуравдагч хөрш”-ийн бодлого 1990-ээд оны хүнд үеийг даван туулахад нэмэр болж, үүргээ гүйцэтгэсэн тул одоогийн олон улсын харилцааны шинж байдлыг харгалзан үзэж, энэ бодлогыг зогсоох хэрэгтэй гэсэн санал ч гардаг.

[35]Д. Мягмар, А. Түвшинтөгс, Ж. Чойнхор- “Гуравдагч хөршийн бодлого: Түүхэн уламжлал, өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” өгүүлэл Д. Мягмар- “Аюулгүй байдлын судалгааны зарим асуудал (түүвэр эмхэтгэл)”. УБ. 2012. 67-р тал өгүүлэл. УБ. 2012.

Олон улсын харилцааны түүхийг аваад үзэхэд аливаа бодлого нь тодорхой хугацаанд хэрэгжээд зогссон жишээ байдаг. Харин манай “гуравдагч хөрш”-ийн бодлого бол мөнхийн хөршүүдийн дундах мөнхийн бодлого байх ёстой юм. Энэхүү бодлогод цаг хугацааны хязгаар тавих боломжгүй боловч ил гаргах, эрчимжүүлэх, эсвэл сааруулах, засварлах зэрэг ажлыг хийх боломжтой юм. Тэгвэл энэ бодлого ямар үед тодорч, ямар үед эрчимжиж, эсвэл саарч байх хязгаарыг бид тодорхойлох ёстой юм.[36]

Нэн түрүүнд Монгол Улс хоёр хөршөөсөө хамааралтай байдлаасаа үүдэн Хоёр хөрш- Гуравдагч хөршүүдийн харилцаа хурцдах муудах үед энэ бодлогыг сааруулж, хэлбэрийг нь өөрчилж байх нь зүйтэй. Үндсэндээ энэхүү бодлого саарах, эрчимжих эсэх нь их гүрнүүдийн бодлого, үйл ажиллагаа, хоорондын харилцаа болон олон улсын харилцааны ерөнхий төлөв байдлаас хамааралтай гэж үзэж болох юм.

“Гуравдагч хөрш” гэдэг нь нэгэнт газарзүйн тухайд ярьж байгаа ойлголт биш учраас “гуравдагч хөрш”-ийг сонгох боломжтой. Иймээс манай ардчилал хөгжлийг тууштай дэмжигч, дорвитой хандивлагч, хөрөнгө оруулагч, аюулгүй байдал, хөгжил дэвшил, эдийн засгийн хувьд ач холбогдолтой улс бүр "гуравдагч хөрш” байх боломжтой гэсэн байр суурь ч байдаг.[37]

Тэгэхдээ тодорхой улс орнуудыг нэр заасан явдал улс орнуудыг алагчлан үзсэнтэй адил хэмээн шүүмжлэл гардаг.[38] Тухайлбал “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд “АНУ, Япон, ЕХ, Энэтхэг, БНСУ, Турктэй” л түншлэлийн харилцаа хөгжүүлнэ хэмээн тодотгтон тусгасан байна. Энэ нь улс орнуудтай харилцах явдлаа ялгаварлан гадуурхсан маягтай[39] гэж зарим судлаачид үзэх болжээ. Мөн чанартаа үнэхээр “Гуравдагч хөрш”-ийн бодлого дан ганц өрнөдийн зарим орнуудтай хоёр талт харилцаагаа хөгжүүлэхээс хавь илүү өргөн, гүнзгий, онолын үндэстэй ойлголт байх нь зүйтэй билээ.

“Гуравдагч хөрш”-ийн бодлогын зорилго нь бодлогын дагуул шинжийг арилган бие даасан гадаад бодлогод шилжүүлэх явдал байв. “Гуравдагч хөрш”-ийн бодлого нь улс төрийн энэхүү үүргээ биелүүлсэн боловч харамсалтай нь хөрсжүүлж чадсангүй, эдийн засагжуулах дараагийн шатанд хэрхэн шилжихээ

[36]Д. Мөнхтөр- *Монгол Улсын гадаад бодлогын анхны үзэл бариmтлал батлагдсаны 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал дээр хэлсэн үг.”* УБ. 2014.
[37]Мөн тэнд
[38]Г. Төмөрчулуун- “*Монгол Улсын Гадаад бодлогын 1994 оны үзэл бариmтлал: Дөрвөн “Д”-гийн чиг шугам”*
[39] Р.Болд- “Монголын Геополитикийн зарим асуудлууд” Улаанбаатар, 2019, 39-р тал

тодорхойлж чадалгүй будилсаар Монгол “дагуул” болох шинж төлөв бүрэлдэж байна. Нэгэнтээ Монголын сонголт хязгаарлагдмал тул эдийн засгийн “дагуул” болох нь ойлгомжтой, харин ядаж улс төрийн “дагуул” болохгүй байх нь дараагийн зорилт юм.

Монголын геополитикийн бодлогын тулгамдсан болон хэтийн зорилт нь амьдрах эдийн засгийн орон зайгаа бусдад алдсан ч оршин тогтнох улс төрийн орон зайгаа алдахгүй байхад л оршино. Дахин “дагуул” болохгүйн тулд “гуравдагч хөрш”-ийн бодлого Монголд хэрэгтэй болно. “Гуравдагч хөрш”-ийн бодлого нь оршин тогтнохын баталгаа ч биш боловч үндэсний аюулгүй байдлын үүднээс нэг ёсондоо “тогтоон барих” сэрэмжлэх бодлого, хэрэгсэл болно.[40]

2.4. Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа *(Үндэсний аюулгүй байдлын үзэл бариmтлалын 3.1.1.6; Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн 3.2.1-р заалт)*

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Хөрш хоёр орон, АНУ, НАТО-гийн гишүүн орнууд, Европын Холбоо, Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлж, олон улсын энхийг дэмжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно”[41] хэмээн тусгасан.

Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичигт “хөрш орнуудтай олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлэх”[42] гэж заасан.

Энэ хүрээд Монгол Улсын бусад орнуудтай тогтоосон батлан хамгаалах салбарын харилцаа тогтмол өргөжин тэлсээр байгаа.

Монгол Улсын батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны уламжлал болон бусад тодорхой хүчин зүйлсээс шалтгаалан Монгол Улс энэ салбарт нэн түрүүнд ОХУ-тай хамтран ажиллах зайлшгүй шаардлага тулгардаг. Тэр утгаараа ОХУ, Монгол Улсын шинэ цагийн харилцааг тодорхойлоход батлан хамгаалах салбарын харилцаа онцгой байр суурь эзэлсээр байна.

[40] Р.Болд- “Монголын Геополитикийн зарим асуудлууд” Улаанбаатар, 2019. 40-р тал
[41] “Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал” 2010.07.15, 3.1.1.6-р заалт
[42] Батлан хамгаалах бодлогын үндэс. 2015.10.08., 3.2.1 заалт

Монгол Улс өмнөд хөршөөсөө зарим салбарт хэт хараат байгаа тул хоёр хөршийнхөө нөлөөг тэнцвэржүүлэхийн тулд ОХУ-тай тогтмол, идэвхтэй хамтран ажиллаж байх шаардлагатай салбаруудын нэг нь батлан хамгаалах салбар мөн.

Монгол Улс “Гуравдагч хөрш” орнуудтай батлан хамгаалах салбарт идэвхтэй хамтран ажиллаж буй нь талуудын хамтын ажиллагааны нэгэн чухал чиглэл болж, олон улсын тавцанд Монгол Улсын нэр хүндийг өсгөх, өндөр хөгжилтэй орнууд болон олон улсын байгууллагуудаас зээл, тусламж авахад шууд хувь нэмэр оруулж байна.

Тэгэхдээ Монгол Улсын Умард Атлантын Гэрээний байгууллага /НАТО/-тай тогтоосон түншлэлийн харилцаа Монгол Улсын энхийг эрхэмлэсэн гадаад бодлогод нийцэх эсэх асуудал өнөөг хүртэл хөндөгдсөөр байна.

НАТО 30 гишүүн оронтойгоос гадна Энхийн төлөө түншлэлийн 21 улс, Газар дундын тэнгисийн яриа хэлэлцээний түнш 7 улс, Истанбулын хамтын ажиллагааны санаачлагын түнш 4 улс, Даян дэлхийн түнш 9 улстай түншлэлийн харилцааг хөгжүүлж буйн дотор Монгол Улс багтаж байгаа юм.[43]

Монгол Улс НҮБ-ын мандаттай олон улсын энхийг сахиулах ажиллагаанд идэвхтэй оролцож байгаа нь “энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагааг идэвхтэй дэмжих” зарчимтай шууд нийцэж байгаа ч НАТО-той тогтоосон түншлэлийн хүрээнд Ирак, Афганистанд энхийг дэмжих ажиллагаанд оролцсон нь гадаад бодлогын зарчимд нийцэх эсэх асуудлаар судлаачид одоог хүртэл харилцан адилгүй байр суурьтай байгаа нь нийгэмд төдийгүй олон улсын түвшинд ч энэ талаар ташаа ойлголт, тодорхойгүй байдал газар авах эрсдэлтэй байна.

2.5. Монгол Улсын аюулгүй байдлыг баталгаажуулах асуудлаарх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолууд *(Үндэсний аюулгүй байдлын үзэл бариmтлалын 3.1.1.7; Гадаад бодлогын үзэл баимтлалын 13-р заалт)*

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Монгол Улсын олон улсын аюулгүй байдлыг баталгаажуулах асуудлаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тогтоолуудын үзэл санааг хэрэгжүүлэх чиглэлд Нэгдсэн

[43] НАТО-ийн албан ёсны цахим хуудас https://www.nato.int/cps/en/natohq/51288.htm

Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн гишүүн орнууд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллана”[44] хэмээн тусгасан байна.

Монгол Улсын олон аюулгүй байдлын асуудлаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар батлагдаж, одоог хүртэл тогтмол хэрэгжилтийг нь тогтмол хэрэгжиж буй маш чухал тогтоол нь “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, Цөмийн зэвсгээс ангид статусын тухай” 53/77D тоот тогтоол юм.

1998 онд батлагдсан энэхүү Тогтоолд Монгол Улс цөмийн зэвсэггүй статусаа тунхагласныг сайшаан, НҮБ-ын гишүүн улсууд, тэр дундаа цөмийн зэвсэгтэй таван гүрнийг Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдал, эдийн засгийн аюулгүй байдал, экологийн тэнцвэр, цөмийн зэвсэггүй статус түүнчлэн хараат бус гадаад бодлогыг нь бэхжүүлэн баталгаажуулахад шаардлагатай арга хэмжээ авахыг уриалжээ. Энэхүү тогтоолын дагуу Монгол Улсын Цөмийн зэвсэгээс ангид статус болон олон улсын аюулгүй байдал хангагдаж буй эсэхийг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2 жил тутамд нэг удаа хэлэлцэхээр тусгасан.

Манай санаачлан оруулсан тогтоолын төслөөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 53 дугаар чуулганаас батлан гаргасан тогтоолд “Цөмийн зэвсэггүй статус нь угтаа улс орнуудын үндэсний аюулгүй байдлыг хангах нэг арга хэрэгсэл мөн гэдгийг иш үндэс болгон, Монгол Улс цөмийн зэвсэггүй байх статусаа тунхаглан зарласныг сайшаан хүлээн авч, Монгол Улс хоёр хөрш оронтойгоо сайн хөршийн тэнцвэртэй харилцаа хөгжүүлж байгаа нь бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, тогтвортой байдлыг бэхжүүлэх нэг чухал хүчин зүйл болж байгааг сайшаан дэмжиж, тус улсын цөмийн зэвсэггүй статус, бие даасан гадаад бодлогыг бататган бэхжүүлэх асуудлаар шаардлагатай арга хэмжээ авах талаар Монгол Улстай хамтран ажиллахыг нийт гишүүн орнуудад, түүний дотор цөмийн зэвсэгтэй 5 улсад уриалж байна”[45] хэмээн тусгасан нь олон улсын эрх зүйн талаасаа Монгол Улсын гаргасан томоохон амжилт мөн.

Тиймээс Монгол Улс цаашдаа энэхүү тогтоолыг ашиглан НҮБ-ын хүрээнд идэвхтэй дипломат ажиллагаа явуулах, тэр дуднаа Аюулгүйн Зөвлөлийн гишүүн орнуудтай энэ асуудлаар хамтран ажиллах боломж, шаардлага бий.

---

[44] “Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал” 2010.07.15, 3.1.1.7-р заалт

[45] Ч.Агваандамдин- “Тусгаар тогтнол ба дипломат бодлого, үйл ажиллагаа” Улаанбаатар, 2016, 250-р тал

Олон улсад цөмийн зэвсэг хураах асуудлаар тогтсон жишгээр Цөмийн зэвсэгтэй таван гүрэн буюу НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн орнууд болон тэдгээрийн цөмийн шүхэр доорх орнууд цөмийн зэвсэг хураах, үл дэлгэрүүлэх, устгах тухай асуудал хөндөгдөхөд тун таагүй ханддаг. Тэр ч утгаараа 53/77D тогтоолыг ч мөн 1 эсвэл 2 удаа хэлэлцэж, тогтоол батлуулаад дахин хэлэлцэхгүй хаах бодолтой байгаагаа мэдэгдэж байсан. Харин Монголын тал өөрийн цөмийн зэвсгээс ангид статус болон олон улсын аюулгүй байдлын талаар тусгасан энэхүү тогтоолыг Ерөнхий Ассамблейгаар хоёр жил тутам хэлэлцдэг асуудал болгож чадсан.

Цаашдаа ч их гүрнүүдийн зүгээс энэхүү тогтоолыг тогтмол хэлэлцэхийг зогсоох асуудлыг хөндөх магадлалтай тул Монгол Улс тогтоолыг тогтмол хэлэлцэж буйг үр дүнтэй ашиглах, шаардлагатай болохыг нь олон улсад ойлгуулах шаардлага бий.

Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид статусын талаар 2012 онд Их таван гүрэн улс төрийн баталгаа олгосон. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн, цөмийн зэвсэгтэй таван улс Монгол Улсын “Цөмийн зэвсгээс ангид статус”-ын талаар хамтарсан тунхаглалдаа Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид статусыг хүндэтгэх, түүнийг зөрчсөн аливаа алхам хийхгүй байхаа тунхагласан.

Тэгэхдээ Монгол Улс цаашдаа цөмийн зэвсэггүй статусаа эрх зүйн баталгаатай болгох, эсвэл дангаар “цөмийн зэвсэггүй бүс” болох чиглэлд идэвхтэй ажиллах ёстой гэж үздэг шинжээчид бий. Харин энэ чиглэлд ажиллахад 53/77D ач холбогдолтой байх боломж бий.

Өөрөөр хэлвэл, Ерөнхий Ассамблейгаас манай асуудлаар цаашид гаргах тогтоолд Цөмийн зэвсгээс ангид статусыг албан ёсоор дэмжсэн заалт оруулах хэрэгтэй байна.[46]

2.6. Бүс нутгийн тогтвортой байдал, аюулгүй байдлын хамтын ажиллагаа *(Үндэсний аюулгүй байдлын үзэл бариmтлалын 3.1.1.8-р заалт; Гадаад бодлогын үзэл баиmтлалын 14-р заалт)*

Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалд “Ази, Номхон далайн бүс нутаг Зүүн Ази, түүний дотор Зүүн хойд Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх,

[46] Ж.Энхсайхан- “Монгол Улсын Цөмийн зэвсгээс ангид статус: Цаашид тавих зорилт” илтгэл “Монгол Улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс болгохоор зарласны 25 жил: үр дүн, цаашид тавих зорилт” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ, 2017, 68-р тал

аюулгүй байдлын хамтын ажиллагааны механизм бий болгоход чиглэсэн бүс нутгийн орнуудын бодлого, үйл ажиллагааг идэвхтэй дэмжиж оролцоно[47]" хэмээсэн бол Гадаад бодлогын үзэл баримтлалд "Азийн бусад улстай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцох, Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж оролцоно[48]" хэмээн тусгасан.

Энэ асуудлыг хөндөхийн тулд нэн түрүүнд Ази, Номхон далайн бүс нутаг, тэр дундаа Зүүн хойд Азид аюулгүй байдлын хамтын ажиллагааны тогтолцоог бусад бүс нутагтай харьцуулахад сул хөгжсөн болохыг харгалзах шаардлагатай.

Өөрөөр хэлбэл, Монгол Улс бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны тогтолцоог дэмжихийн тулд энэ бүс нутагт бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажсан, хамтын аюулгүй байдлын тогтолцоо бүрэлдэн тогтох шаардлагатай юм.

Ази, Номхон далайн бүс нутагт олон улсын харилцааны шинж чанар эрс өөрчлөгдсөн ч аюулгүй байдлын хамтын тогтолцоо бүрэлдэн бий болоогүй, янз бүрийн үүдэлтэй зөрчил, сөргөлдөөн үргэлжилсээр байгаа нөхцөлд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг ханган улмаар үндэсний эрх ашгаа урьтал болгосон, тогтвортой хөгжлийн асуудлаа шийдвэрлэх зорилго бүхий аюулгүй байдлын бие даасан, бодлого, үйл ажиллагаа явуулах тийм шаардлага тулгарсан, туйлын хариуцлагатай цаг үед бид амьдарч байна.[49]

Монгол Улс бүс нутгийн хамтын ажиллагаанд оролцохдоо Ази, Номхон далай эсвэл Төв Азийн бүс нутаг дээр түшиглэх боломжтой гэж үздэг.

Монгол Улс Төв Азийн бүс нутаг дээр суурилж бүс нутгийн хамтын ажиллагаанд оролцох нь үндсэндээ хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан таван улс болон хоёр хөрштэйгөө түлхүү харилцах тухай ойлголт юм. Магадгүй бид ЗХУ-ын дагуул улс, Төв Азийн таван орон ЗХУ-ын бүрэлдэхүүн хэсэг байж байгаад 1990-ээд оноос бие даасан гадаад бодлого явуулах болсноороо ижил төсөөтэй

---

[47] "Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал" 2010.07.15, 3.1.1.8-р заалт

[48] Гадаад бодлогын үзэл баримлал. 2011., 14.3-р заалт

[49] Д. Мягмар- "*Геополитикийн шинэ нөхцөл байдал: Их гүрнүүдийн геостратегийн ашиг сонирхлын дунд.*" "Орчин үеийн олон улсын харилцааны шинэ чиг хандлага ба Монгол улс" эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ. 2011. 20-р тал.

байж болох ч 20 гаруй жилийн хөгжлийн зам, арга барил, гадаад бодлогыг харахад бид Төв Азийн орнуудаас ихээхэн ялгаатай болсон.

Төв Азийн таван орны хөгжлийн чиг хандлага нь тодорхой бус байна. Одоогийн байдлаар эдгээр оронд бүгдэд нь авторитар засаглал ноёрхож байгаа бөгөөд улс төрийн сөрөг хүчнийг хүлээн зөвшөөрөөгүй, хүний эрх, эрх чөлөөг ноцтой хөсөрдүүлсэн авилгал, хээл хахууль ихээхэн газар авсан байдалтай байна.[50]

Тэгэхдээ сүүлийн жилүүдэд харьцангуй хаалттай байсан Төв Азийн орнуудтай, тухайлбал, Казакстан, Туркменистан улсуудтай олон улсын авто тээвэр, агаарын харилцаа, хүнс хөдөө аж ахуй, аялал жуулчлал, соёлын салбарт хамтран ажиллаж байна.

Төв Ази дээр түшиглэнэ гэдэг нь үндсэндээ ШХАБ-д элсэх тухай асуудал. Хэдийгээр манай хоёр хөршийн зүгээс ШХАБ-д элсэхийг тойруу замаар шахсаар байгаа ч бид өнөөг хүртэл ажиглагчийн статустай хэвээр байгаа. Хэдийгээр ШХАБ-д элссэнээрээ бидний хоёр хөрштэйгөө хөгжүүлж буй харилцаа эрс сайжрах боломжтой мэт боловч ШХАБ-ыг АНУ-ын эсрэг чиглэсэн механизм гэх хандлага зарим судлаачдын дунд буйг харгалзан үзвэл бид энэ асуудалд ихээхэн болгоомжтой хандах шаардлагатай

Харин Зүүн хойд Азийн харилцаанд идэвхтэй оролцож, энэ бүс нутгийн орон байснаараа бид хоёр хөрш болон “гуравдагч хөрш”-үүд болох АНУ, Япон, БНСУ-тай харилцах боломж бүрэлдэж буй юм. Мэдээж Төв Ази Монгол Улсын гадаад бодлогод тодорхой байр суурь эзэлсэн хэвээр ч бидний бодлого Зүүн хойд Ази дээр суурилж байна. Түүнчлэн Зүүн хойд Ази дээр суурилсан бодлого явуулснаар өөрсдийн далайд гарцгүй сул талаа хамтын ажиллагаан дээр суурилан нөхөх, хөгжингүй ардчилсан орнуудтай болон хоёр хөрштэйгөө нэг бүс нутгийн хүрээнд харилцсанаараа гадаад бодлогын тэргүүлэх хоёр чиглэлээ нэгэн зэрэг хангах боломж бидэнд гардаг.

Түүгээр ч зогсохгүй Монгол Улсыг энэ бүс нутагт хамаатуулах сонирхол их гүрнүүдэд байх үндэстэй. Бид бол Европ, Азийн зааг дээр оршдог стратегийн өвөрмөц байрлалтай орон. Цаашлаад байгалийн баялаг ихтэй байдал том гүрнүүдийн, тэр дундаа Зүүн хойд Азийн том гүрнүүдийн анхаарлыг татсаар

[50] М. Батчимэг- “*Шатрын өрөг дэх Монгол Улс*” УБ, 2012. 149-р тал

байгаа. Мөн түүнчлэн Солонгосын хойгийн асуудлыг шийдвэрлэх үйл явцад биднийг онцгой хувь нэмэр оруулах боломжтой гэж харах үндэс байгаа.

Үүнээс үүдэн Зүүн хойд Азид үүсч буй болсон геополитик, геостратегийн орон зайд Монгол Улсын эзлэх байр суурийг зөв тодорхойлох нь манай хөгжлийн тулгамдсан чухал асуудал болж байна. Монгол Улсад Орос, Хятадаас гадна АНУ, Зүүн хойд Азийн бусад оронтой идэвхтэй, найрамдалтай, харилцан ашигтай хамтран ажиллах шаардлага бий бөгөөд үүнийг аль хэр ухаалаг, оновчтой, алсын хараатай шийдвэрлэж чадахаас манай аюулгүй байдлын ирээдүй хамаарна гэж үзэж болох юм. [51]

Бүс нутгийн хэмжээний аюулгүй байдлын олон талт хамтын ажиллагааны бүтэц бий болгоход идэвхтэй оролцохын тулд Монгол Улс бүс нутгийн орнуудтай тогтоосон хоёр талт харилцаа, хамтын ажиллагаагаа ч өргөжүүлэн хөгжүүлэх нь зохистой юм. Бид жижиг орны хувьд бүх орнуудтай найрсаг харилцаагаа тэнцвэртэй хөгжүүлснээрээ аль нэг талын эсрэг чиглэж буй мэт сэтгэгдэл төрүүлэхгүй байх нь аюулгүй байдалд чухал ач холбогдолтой зүйл мөн.

[51] Д. Мягмар- “*Геополитикийн шинэ нөхцөл байдал: Их гүрнүүдийн геостратегийн ашиг сонирхлын дунд.*” “Орчин үеийн олон улсын харилцааны шинэ чиг хандлага ба Монгол улс” эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ. 2011. 23-р тал.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ОЛОН УЛСЫН ГЕОПОЛИТИК, ГАДААД ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛ

Улс орны аюулгүй байдалд хамаарах геополитикийн хүчин зүйлст тухайн улс орны газар зүйн байршил болон эдийн засаг, улс төрийн хийгээд төр улс, нийгэм, хүн ардын нууцлаг, хаалттай байх онцлог хүчин зүйлс хамаарах бөгөөд эдгээр нь тухайн улс орны аюулгүй байдлыг хамгаалах нийгэм, улс орон, хүн амын эрх ашиг, сонирхлыг тусган илэрхийлдэг.

Монгол Улс түүхийнхээ бүхий л үед өрнө, дорныг холбох гүүр, уулзвар зааг болсон өргөн уудам нутагтай (дэлхийн газар нутгийн 1-ээс илүү хувь) ч дэлхийн хоёр том гүрний завсар оршдог, далайд гарцгүй, газар зүйн байрлалаараа дэлхийн том гүрнүүдийн стратегийн сонирхлын онцгой объект болсоор ирсэн.

Ийм байршил нь бид хоёр хөршид нөлөө үзүүлж чадах гурав дахь орон зайг өөрийн оронд бий болгох зайлшгүй хэрэгцээг бий болгож байгаа юм. Энэ нь үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын асуудлыг өвөрмөц байдлаар хөндөж, төрийн хар хайрцагны ухаалаг бодлогод тулгуурлан нөхцөл байдалтай уялдуулан стратегиа сонгохыг нөхцөлдүүлж байдаг.

Манай улсын газар зүйн ийм өвөрмөц байршилтай холбоотой “гуравдагч хөрш”-ийн талаарх бодлого, стратегийн онцлогийг эрдэмтэн “манай “гуравдагч хөрш”-ийн бодлого бол мөнхийн хөршүүдийн дундах мөнхийн бодлого байх ёстой юм. Энэхүү бодлогод цаг хугацааны хязгаар тавих боломжгүй боловч ил гаргах, эрчимжүүлэх, эсвэл сааруулах, засварлах зэрэг ажлыг хийх боломжтой юм. Тэгвэл энэ бодлого ямар үед тодорч, ямар үед эрчимжиж, эсвэл саарч байх хязгаарыг бид тодорхойлох ёстой юм”[52] гэж арга зүйн талаас нь тун оновчтой томьёолсон байдаг.

“Улсын тавилан байршлаасаа” хамаарах зүй тогтол нь стратегийн нэг чухал шинжийг энэхүү байршил илэрхийлэхээс гадна байршил нь эргээд стратегийн нөхцөл болох бөгөөд нөхцөлөө дагаж стратегиа сонгож хэрэгжүүлэх ёстойг харуулж байна.

Энэ нь манай улсын хувьд стратеги ихээхэн уян хатан шинж чанартай байх шаардлагыг нөхцөлдүүлж байна.

[52] Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын материал. УБ., 2014. 142 х. Д.Мөнхтөрийн хэсэн үг: т. 92.

Эдгээр онцлогийг харгалзсан нэгдсэн бодлогыг Монгол Улс Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа “ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Чингэхдээ үндэсний эрх ашиг, харилцааны түүхэн уламжлалыг харгалзан бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг эрхэмлэж, бүхэлдээ тэнцвэртэй харилцахыг эрмэлзэнэ”, “Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ” гэж тодорхойлсон бол Гадаад бодлогын үзэл баримтлалд "ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр оронтой харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзах”, “АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улстай холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх”, “Азийн бусад улстай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцох, Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж оролцох”, “Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд болон олон улсын санхүү, худалдаа, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаа идэвхтэй үргэлжлүүлэх, дэлхийн засаглал дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллах”, “Хөгжиж байгаа улсуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхийн зэрэгцээ Нэгдсэн Үндэстний Байгууллага, “77”-гийн бүлэг, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэг олон талын хүрээнд хамтран ажиллах” гэсэн нь “гуравдагч хөрш”-ийн хувьд бодлогоос гадна стратегийн шинжийг агуулсан байна.

Үндэсний тагнуулын академийн судалгаанаас харахад судалгаанд оролцсон иргэдийн 63 хувь нь Гадаад бодлогын үзэл баримтлалд “аль нэг улсыг тусгайлан нэрлэх нь зохимжгүй”, 21 хувь нь “маш зөв бодлого”, 16 хувь нь “манай улсад ашиггүй бодлого” гэж хариулсан байна. Иргэд “гуравдагч хөрш”-ийн бодлогыг дэмжиж байгаа ч зарим улсыг тусгайлан нэрлэсэн явдалд шүүмжлэлтэй ханддаг

нь ажиглагдсан байна. Энэ нь нөхцөл, стратегийн байршилтай холбоотой дүгнэлт юм.

Их гүрнүүдийн геополитикийн ашиг сонирхлын Монгол Улсын аюулгүй байдалд үзүүлж болзошгүй эрсдэлүүд

Геополитик нь орон зайд хяналтаа хэрхэн тогтоох талаарх мэдлэгийн тухай шинжлэх ухаан бөгөөд энэ нь улс төрийн шинжлэх ухааны бүрэлдэхүүн хэсэг гэж судлаачид нийтээр хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ харин түүний судлах зүйл болох "орон зай" гэдгийг хэрхэн авч үзэх талаар эдүгээ хүртэл мэтгэлцсээр байгаа юм. Ерөнхийдөө геополитикийг улс орны стратегийн чадавхад харилцан холбоотойгоор нөлөөлдөг газар зүй, түүх, улс төр болон бусад хүчин зүйлсийг судалдаг шинжлэх ухаан гэх болжээ.[53] Геополитикийг зөвхөн том гүрний хувьд авч үзэх юм уу, тэгвэл жижиг, дунд улс гүрэнд геополитик ямар хамаатай юм, тэд ч бас амьдрах, оршин тогтнох орон зайн төлөө тэмцэлддэг зүй ёсны асуудал юм.

Монгол Улс геополитикийн аюулгүй байдлаа хангах аливаа тохиолдлын хувьд АНУ-ын Ази судлаач Скалапиногийн "Олон улсын харилцаанд Монголын хийх сонголт даан ч хязгаарлагдмал. Уудам газар нутаг, цөөн хүн амтай тус улс нь нэг бол Зөвлөлт нөгөө бол Хятадаас л хамаарна... Хятад нь нэг л өдөр тус улсыг дахин хяналтандаа авна гэдэг бодол Монголчуудын тархинд гүн суужээ. БНМАУ-ын удирдагчид хүчээр хятадчлагдсан БНМАУ-д буйгаас олон тооны монголчууд БНХАУ-д байдгийг мартаддаггүй байна. Гэхдээ Монгол нь үндсэн бүхий л гүрнүүдтэй харилцах нь түүнд л ашигтай юм [54] гэснийг санах ёстой юм.

Юуны өмнө дээр өгүүлсэнчлэн аливаа том сорилт тулгарахад Монгол Улс мөнхийн хоёр хөршийнхөө хувьд нэг талыг дэмжсэн стратеги баримтлахгүй, “гуравдагч хөрш”-ийн талаар зөв стратеги хэрэгжүүлэх шаардлага, нөхцөл бий болно.

Иймд *нэгд*, АНУ, БНХАУ-ын хооронд үүсэж болзошгүй харилцааны; *хоёрт*, АНУ, ОХУ-ын хооронд үүсэж болзошгүй харилцааны; *гуравт,* ОХУ, БНХАУ-ын хооронд үүсэж болзошгүй харилцааны Монгол Улсын аюулгүй байдалд тулгарах эрсдэлийн талаар дараах байдлаар таамаглалаа. Үүнд:

3.1. АНУ, БНХАУ-ын хооронд үүсэж болзошгүй харилцааны Монгол Улсын аюулгүй байдалд учрах боломж, эрсдэл

[53] Удирдлагын Акакдемиас хэвлүүлсэн "Нээлттэй лекц: 2016-2017 оны хичээлийн жил", УБ ,2017 эмхтгэлд хэвлэгдсэн лекц

[54] Robert Scalapino “Major Power Relations an Northeast Asia” The Asia Socierty 1987, p. 45-46

3.1.1. Америк, Хятадын хоорондүүсэж болзошгүй сөргөлдөөний үед учрах эрсдэл

Сөргөлдөөний хамгийн муу хувилбар нь Тайваний болон Өмнөд Хятадын тэнгис дэх асуудлаас болж тус хоёр улсын хоорондхурцадмал байдал эрс нэмэгдэж, улмаар энэ нь зарим судлаачдын үзэж байгаагаар зэвсэгт мөргөлдөөнд хүргэж болох магдалалтай юм. Олон улсын харилцааны хүндийн жин Азид, Евразид шилжих тусам Америк, Хятадын харилцаа нь хүйтэн дайны үеийн ЗХУ, АНУ-ын харилцааг орлох төдийгүй хэтдээ олон улсын харилцааны хоёр туйл болох хувилбарыг зарим судлаач үгүйсгэхгүй байгаа юм. Кессинжер "БНХАУ хүчирхэгжихийн хэрээр Америк, Хятад хоёр өрсөлдөх нь гарцаагүй, гэхдээ энэхүү өрсөлдөөн хязгаартай гэдэг талаар хоёр тал тохиролцох хэрэгтэй" гэж байв.[55] Харин Хантингтон үзэхдээ "өрнөдийн их зан, лалын тэвчээргүй байдал, хятадын ертөнц эдгээрийн харилцан үйлдлээс хамаатай аюултай мөргөлдөөн ирээдүйд гарах болов уу" гэжээ[56].

Энэ тохиолдолд *Монгол Улс зэвсэгт мөргөлдөөн үүсгэсэн хоёр улсаас өөрсдийн байр суурийг дэмжихийг шаардсан дарамт шахалтад орох, түүнийг дагасан эдийн засаг, батлан хамгаалах тусламж, дэмжлэгийн хязгаарлалтад өртөх магадлал өндөр байх болно.* Түүнчлэн хоёр хөрш хэзээд бидний мөнхийн хөрш тэдгээртэй хүссэн хүсээгүй харилцаанд орохоос өөр аргагүй учир *манай улсын аюулгүй байдлын хэтийн төлөв Америк, Хятадын хоорондын зэвсэгт мөргөлдөөний үе дэх Оросын байр суурь болон мөн НҮБ-ын байр суурины хувилбараас шууд хамаарна*. Үүнд:

- Орос, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа үргэлжилж, хэрэв НҮБ зэвсэгт мөргөлдөөнөөр бус, яриа хэлэлцээрээр асуудлыг шийдвэрлэх байр суурь баримтлах тохиолдолд Монгол Улс НҮБ-ын байр суурийг дэмжих, хэрэв НҮБ зэвсэгт мөргөлдөөнд Хятадыг буруутгасан байр суурь илэрхийлж, асуудлыг Хятадын талаас буулт хийж яриа хэлэлцээрээр шийдвэрлэхийг уриалах юм бол Монгол Улс НҮБ-ын байр суурийг дэмжвэл өмнөд хөршийнхөө зүгээс ноцтой дарамт шахалтад өртөх болно.
- Орос, Америктай түр холбоотны харилцаа тогтоох тохиолдолд Орос, Хятадын хоорондын харилцаа хурцдах ба Монгол Улс НҮБ-ын байр суурь

[55] “America’s Role in Asia” The Asia Foundation 2015, p.112
[56] Samuel P.Huntington “The Clash of Civilizations and the Remaking of World Order” Touchstone Book 1996, p.183

ямар байхаас хамаарахгүйгээр зэвсэгт мөргөлдөөнийг зөвтгөхгүй, аль нэгийг нь дэмжихгүй төвийг сахисан байр суурь илэрхийлэх.

- Үүсэж болох хоёр стратегийн өрнөлийн үед зэвсэгт мөргөлдөөнд оролцогч хоёр гүрний аль алиных нь зүгээс өөрийгөө дэмжүүлэх шахалт, дарамт ирэх магадлал өндөр байх болно. Энэ тохиолдолд Монгол Улс НҮБ болон Орос, бусад орнуудын дэмжлэгт тулгуурлах.
- *Дээрх сценарын дагуу Америк, Хятад хоёрын хооронд зэвсэгт мөргөлдөөн үүсэхгүйгээр худалдааны дайн улам гүнзгийрч, удаан хугацаагаар үргэлжлэх тохиолдолд Монгол Улс аюулгүй байдал, ялангуяа улс төр, эдийн засаг, бүрэн эрхт байдлын хувьд том сорилттой нүүр тулгарна*. Судлаачид чөлөөт эдийн засгийн онолын үүднээс худалдааны дайн аль аль талдаа ашиггүй. Тэр дундаа дэлхийн хоёр том гүрний хоорондын худалдааны дайн дэлхийн эдийн засгийг ч бүхэлд нь туйлдуулна. Ингэснээр гуравдагч орнууд ч хохирно гэж үзсэн байдаг. *Тиймээс манай эдийн засгийн хөгжилд өндөр эрсдэл бий болно.* Ийм нөхцөл үүсэхэд Гадаад бодлогын үзэл баримтлалын дагуу ОХУ, Япон, Герман, Энэтхэг, БНСУ болон бусад улс оронтой тогтоосон нягт хамтын ажиллагаа нь худалдааны дайнаас ирэх геополитикийн дарамт, шахалтыг даван туулах гол стратеги байж болох талтай.

3.1.2. Америк, Хятадын хоорондын харилцаа хоршсон үеийн боломж, өрсөлдсөн үеийн эрсдэл

Нэг талаас Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридор байгуулж, хоёр хөршийг төдийгүй Ази, Европыг холбох гүүр болох боломжтой байх. Үр дүнд нь эдийн засгийн зүүн коридор буюу Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр зам баригдсанаар Монголын ашигт малтмал, ОХУ-ын бараа бүтээгдэхүүнийг БНХАУ-ын хамгийн том хоёр муж болох Ляонинг, Хэбэй мужийн зах зээлд богино хугацаанд хүргэх гарц бий болно[57]. Улмаар БНХАУ-ын Тяньжинь, ОХУ-ын Владивостокийн боомтоор дамжин далайд гарцтай болох буюу түүхий эдийг гуравдагч зах зээлд гаргах боломжтой болно. Хоёр хөршийн эдийн засаг хурдацтай хөгжиж байгаа тохиолдолд бүс нутгийн эдийн засгийн интеграцийн ард хоцрох, тээвэр, худалдаа, техник, технологийн хувьд хоцрогдмол байдалтай үлдэхгүйн тулд хоёр болон гурван талт урт хугацааны харилцан ашигтай

[57] Шинэ төмөр зам төсөл

хэлэлцээр байгуулах, экспортын бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд хүргэх тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх ачаа, тээврийн эргэлтийг нэмэгдүүлэх боломж байж болох юм.

Нөгөө талаас ухаалаг бодлого явуулахгүй бол Хятад улсын зүгээс өр зээлийн дарамтад орж болзошгүй хэтийн төлөв хүлээж буйг дараах баримтаас харж болно. “Нэг бүс, нэг зам” санаачлагын хүрээнд БНХАУ-аас их хэмжээний зээл авсан хөгжиж буй болон буурай хөгжилтэй улс орнууд зээлээ эргүүлэн төлж чадахгүйд хүрч “өрийн занга”-нд унах эрсдэл хүлээж байна. Вашингтоны Олон улсын хөгжлийн төвөөс (Center for Global Development) гаргасан судалгаагаар Монгол Улс Хятадын “өрийн занга”-нд унах өндөр магадлалтай 8 орны жагсаалтанд Жибути, Малдив, Лаос, Монтенегро, Киргизстан, Пакистан, Тажикстан улсуудын хамтаар бичигдсэн байна[58].

3.2. АНУ, ОХУ-ын хоорондүүсэж болзошгүй харилцааны Монгол Улсын аюулгүй байдалд учрах боломж, эрсдэл

3.2.1. Америк, Оросын хоорондын харилцааны сөрөг үед учрах эрсдэл

буюу *“дэлхийн байгалийн нөөцийн ба дэлхийн баялгийн хуваарилалт дээрх хяналтын төлөөх тэмцэл хүчтэй болж буй”* нөхцөлд АНУ өөрийн холбоотон Европын холбооны орнуудад Оросын нефть, байгалийн хийн экспортыг нь хязгаарлах бодлого явуулж, НАТО-гийн зүгээс Украйныг зэвсэг, техникээр дэмжин, тусалснаар ОХУ-тай харилцаа улам хүйтэрнэ. Энэ сценартай холбоотой дараах таамаглалыг судлаач дэвшүүлсэн байдаг: “Украйны хямрал тэгэхээр XIX зууны нутаг дэвсгэрийн төлөөх дайралтаас илүүтэй XXI зууны нийлүүлэлтийн сувгийн геополитиктой холбоотой асуудал ажээ. *Урт хугацааны үр дагаврыг авч үзвэл Оросын азгүйтэл холболт илүү сайтай барууны орнуудад ашигтай ч тусаж магадгүй.* Ямагт мууг ёрлож, айдас хуруулж байдаг зарим сэтгүүлчид асуудлыг илүү гүн ухаж хардаггүй шүү дээ: Гэхдээ нутаг дэвсгэрийн "үрэлт" ч заримдаа шинэ урсгалыг бий болгодог. 1970-аад оны Хятад-Зөвлөлтийн "хагарал" Хүйтэн дайны үеийн хоёр том коммунист гүрний харилцааг царцааж орхисон ч энэ бүхний ачаар АНУ-ын хувьд Хятадтай харилцаа тогтоох үүд хаалга нээгдэж, энэ харилцаа нь хоёр орны тус тусдаа Оростой үүсгэсэн харилцаанаас хавьгүй давж гарсан билээ. Эдийн засаг нь муудаж явсан Крымыг (орлогыг нь нэмэгдүүлэхийн

[58]“Examining the debt implications from the Belt and Road Initiative https://www.cgdev.org/publication/examining-debt-implications-belt-and-road-initiative-a-policyperspective

тулд Москвагаас мөрийтэй тоглоомын татваргүй бүс болгох шийдвэр гаргасан) эзэлж, Донбассын үйлдвэржилтийн үеэс балгас шахам болж үлдсэн газарт тулаан өрнүүлсэн үйлдлээрээ Орос нутаг дэвсгэрээ сөөмөөр ахиулж чадсан ч хэрэг дээрээ "жинхэнэ" Украйныг алдаж орхижээ. Учир нь энэ бүхний дараа Киев, баруунтай холбоо харилцаагаа улам бүр зузаатгаад байна. *Цаашлаад, Орос хийн нийлүүлэлтээ тасална гэж сүрдүүлж байгаа нь Европыг Америк, Хойд Африкаас эрчим хүчний өөр эх үүсвэр хайхад хүргэж байна*. Украйн том тулаанд ялагдсан байж болох ч Европ хориод жилийн өмнөөс эхлээд байсан нийлүүлэлтийн сувгийн "олс татах тулаан"-д ялсан явдал боллоо шүү дээ."[59] хэмээн Оросын нөхцөл байдал хүндэрч магадгүй төлөвийг илэрхийлж байсан нь өдгөө биелэлээ олж байгааг илтгэн харуулж байна.

Оросын зүгээс Хятадтай стратегийн иж бүрэн түншлэлийн харилцаагаа улам бэхжүүлж, ШХАБ болон БРИКС-ийн хамтын ажиллагааг өргөтгөж байна. Энэ сценарт Орос, Америкийн хоорондын зэвсэгт мөргөлдөөн үүсэх болзошгүй нөхцөлийг авч үзээгүй нь их гүрнүүдийн хоорондох тулгаралт бага магадлалтай гэж Америкийн судлаачид тооцсон байдгийг харгалзан үзсэн. Харин зарим судлаачид АНУ болон Хятадын хоорондын харилцааны хувьд Өмнөд Хятадын тэнгист зэвсэгт мөргөлдөөн гарна гэж таамагласнаас үзвэл энэ хоёр гүрний хувьд эргэлзээтэй төсөөлөл гэсэн дүгнэлт хийсэнтэй холбоотой.

Ийм нөхцөлд Монгол Улсад АНУ-ын зүгээс Оросын эсрэг хориг, хязгаарлалтын ажиллагаанд нэгдэх талаар шахалт үзүүлэх, манайд үзүүлж буй дэмжлэгээ зогсоох дарамт ирэх магадлал өндөр байх болно.

Манай улс Орос–Монгол–Хятад гэсэн эдийн засгийн коридороо хөгжүүлэх[60] талаар хоёр хөрштэйгээ хамтран ажиллахаас гадна "гуравдагч хөрш"-ийнхөө

[59] Параг Ханна. Дэлхийн соёл иргэншлийн ирээдүйг зураглахуй ХОЛБОЛТЫН ГАЗАРЗҮЙ. УБ., 2018. 427 х.

[60] 2014 онд Душенбед Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагын Дээд хэмжээний уулзалтын үеэр 3 улсын тэргүүн нар анх удаа уулзаж Хятад-Орос, Монгол-Хятад, Монгол-Орос гэсэн хоёр талт хэлэлцээрүүд дээр үндэслэн Монгол-Орос-Хятадын гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлэх хэлэлцээрт гарын үсэг зурсан. Тус уулзалтаар гурван талт хамтын ажиллагааны зарчим, чиглэл, хамтран ажиллах чиглэлүүдийг тодорхойлсон. Тус хэлэлцээрээр 3 улсын төрийн тэргүүнүүд Хятадын Торгоны зам эдийн засгийн бүслүүр, Оросын Евразийн газрын гүүр, Монголын талын зам хөтөлбөрүүдийг харилцан уялдуулахаар тохиролцсон. 2015 оны 7 дугаар сард Төрийн тэргүүнүүд Оросын Уфа хотод хоёр дахь удаагаа уулзаж Орос-Монгол-Хятадын гурван талт хамтын ажиллагааны дунд хугацааны замын зураглалыг албан ёсоор баталгаажуулсан. "Монгол-Хятад-Оросын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр"-т 2016 оны 6 дугаар сард гарын үсэг зурсан нь "Нэг Бүс, нэг Зам"-ын хүрээнд байгуулсан анхны олон талт хамтын ажиллагааны хөтөлбөр болсон байна.[60] "Хөгжлийн зам" хөтөлбөр болон "Нэг бүс, нэг зам" санаачилгыг уялдуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийг 2017 оны 5 дугаар сарын 11-нд байгуулсан. Монгол улсын засгийн газрын 2017 оны 5-р сарын 10-ний өдрийн 142-р тогтоолоор батлагдсан "Хөгжлийн зам" үндэсний хөтөлбөрт:

бодлого, стратегид нөхцөл байдалтай нийцүүлэн тодотогол хийх нь зөв байж болох талтай.

3.2.2 Америк, Оросын соёл иргэншил хоорондын харилцааны үеийн боломж, эрсдэл

А. Америк, Оросын соёл иргэншлийн зөрчилдөөнөөс илүүтэй Хятадын соёл иргэншилтэй зөрчилдсөн үеийн "холбоотны харилцааны" сценар үүсвэл манай хоёр том хөршийн хооронд ихээхэн зөрчилтэй нөхцөл байдал үүснэ. Тиймээс Монгол Улсын аюулгүй байдлын хэтийн төлөвт *нэгд,* Америк, Оросын харилцаанаас хамаарахгүйгээр соёл иргэншлийн хувьд Хятадад уусаж устах аюул заналын эрсдэл, *хоёрт,* хоёр хөршийн хоорондын зөрчлөөс үүдэлтэй дарамт, шахалтууд ирэх болно.

Аливаа улс орон дэлхийд байр сууриа эзлэхэд улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, батлан хамгаалах зэрэг хатуу хүч чухал байр суурийг эзлэх хэдий ч нөлөө бүхий зөөлөн хүчгүйгээр улсын нийт хүч буюу бусдыг дагуулах, өөртөө итгүүлэн үнэмшүүлэх хүч дутах юм. Энэ ойлголтыг хятадын нэрт сэтгэгчийн болоод одоог хүртэл олон мянган жил дагаж мөрдөж төрийн бодлогын суурь болгож байгаа уламжлалт арга барил нь аливаа зүйлийг хүчээр бус аль болох аядуу байдлаар бусдыг дагуулах, түүнийг тухайн зүйлд итгүүлэн дагуулах нь хамгийн зөв зүйтэй гэж үздэг байжээ. *Эртний хятадын ойлголтоор хүмүүний ямар угсаатай, хаана төрсөн зэрэг нь гол бус, харин уул хүмүүн хятад соёлыг хэр зэрэг өөртөө шингээж авсан гэдэг нь шийдвэрлэх зүйл юм. Хэн нэг харь хүмүүн хятадын соёл иргэншлийг хүлээн авч, өөрийн болгож, түүний дагуу амьдарч буй бол тэр хүмүүн хятад хүн болно*." [61] хэмээжээ.

Хятадын түүх шастирт "Аливаа нэг улсыг мөхөөсүгэй хэмээвээс анх түрүүнд түүхийг нь устгаваас зохилтой" хэмээн өгүүлсэн байдаг нь түүхийг нь устгахын тулд юуны өмнө түүнийг өртөөлөн тээгч болох хэл соёлыг устгах санааг агуулж буй юм. Аливаа хүчирхэг гүрэн, дэлхийн бодлогыг тодорхойлогч их гүрнүүд түүхэн тодорхой үед олон улсын харилцааг тодорхойлж байхдаа өөрийн соёл иргэншлийн

- Таван толгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр зам барих
- Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 45,3 км төмөр замыг барих
- Тавантолгой-Сайншанд-Хөөт чиглэлийн 892 км төмөр замын төслийг хэрэгжүүлэх
- Хөөт-Сүмбэр чиглэлийн 380 км төмөр замын төслийг эхлүүлэх
- Оюутолгой уурхайн салбарын 40,4 км төмөр замын төслийн эхлүүлэх
- Хөөт-Бичигт чиглэлийн 234 км төмөр замын төслийг барьж дуусгах ажлыг тус тус тусгасан.

[61] Конрад зайц" Хятад дэлхийн гүрэн эргэн ирж байна" УБ., 2009., 70х

хэм хэмжээнд бусдыг тэнцүүлэх, бусад улс орныг уях бодлого явуулсаар ирсэн. Өнөө үед Хятадын хүн ам нутгаасаа хальж Ази, Европ, Америк тивийг дүүргэх хандлагатай байна. Энэ нь Төв Азийн орнууд болон Оросоор дамжин, Европод нөлөөлөх их гүрний бодлого хэрэгжиж байгаагийн илрэл юм. Түүнчлэн соёлд даяаршлын үзүүлэх нөлөөлөл нь улс төрийн явцуу утгаар үзвэл дэлхийн олон ард түмний үндэсний ухамсрыг соёл-оюуны довтолгоогоор дарах гэсэн алсын зорилготой их гүрний улс төрийн бодлого, үзэл суртлын зэвсэг болж байна.

Ийм хандлага, нөхцөл нь 1 тэрбум 400 гаруй сая хүн амтай Хятад улстай 4000 гаруй километр газраар хиллэдэг 3,5 сая хүн амтай Монгол Улсын хүн ам, удмын сан, соёл иргэншлийн аюулгүй байдлын хэтийн төлөвийг ихээхэн эрсдэлтэй болгож байна.

Судалгаанаас үзэхэд үндэстэн мөхдөг нэг хүчин зүйл нь үндэтний хэл соёл мөхөх явдал юм. Шалтгаан нь “ихэнх цөөн харилцагчтай хэл нь өвөг дээдсийнхээ хэл соёлыг нийгэм, эдийн засгийн өнөөгийн байр суурьтай уялдуулан авч явж чаддаггүй, өөрсдийн хэлний хэрэгцээ, шаардлага, үнэ цэнийг ч тодийлөн сайн ойлгодоггүй эсвэл ялгаварлан гадуурхах үзлээс шалтгаалан үр хүүхдийнхээ амьжиргааг бэхжүүлэхийн тулд эх хэл, соёлоо алдаж, гадны халдлагад өртөх нь элбэг байдаг байна. Хэл нийгмийн асуудал учраас хэлний мөхөл ч мөн цэвэр нийгмийн асуудал гэж үзэх талтай ба хэлний даяаршил нь хэлний мөхлийг дагуулж байдаг учраас нийгмийн харилцаанд төдийлөн идэвхитэй оролцдоггүй жижиг хэлнүүд нь том хэлэндээ уусч мөхдөг байна.”[62]

Доктор Т.Өсөхжаргалын судалгаанд *“Монгол хэлний амьдрах чадвар эрсдэлтэй байгаа нь хэл соёлын аюулгүй байдлын дархлаа бүрэн бий болж чадаагүй, хэл соёлын бодлого, арга хэмжээ дутагдалтай байна.”*[63] гэсэн дүгнэлт хийжээ. Түүний судалгаа “манай улсад “гадны хэл соёлын түрэлтийн аюул “маш их”, хэл соёлын аюулгүй байдлын зорилтод үүргүүдийн хэрэгжилт бүгд эмзэг бөгөөд ихэнх нь “маш эмзэг” байгаа нь эрсдэл бол аюул, эмзэг байдал хоёрын харилцан үйлчлэлийн үр дүн байдаг зүй тогтолын дагуу “их аюул” ба “маш эмзэг” байдал хоёрын харилцан үйлчлэл хэл соёлын аюулгүй байдлын дархлааг *“өндөр эрсдэлтэй”* байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, манай улсын тогтвортой хөгжих оюуны суурь бөгөөд оюуны өв соёл, соёл ба үндэсний үнэт зүйлийг гадны

[62] Ж.Бадамсүрэн “Монголчуудын нутгийн аялгууг хэл хамгаалах бодлогын хүрээнд судалсан нь”, УБ., 2014, 130 х., т. 17-18

[63] Т.Өсөхжаргал. “Монгол хэл соёлын дархлаа бий болгох зарим арга зам” сэдэвт аюулгүй байдлын ухааны докторын диссертац. УБ., 2016

хэл соёл нэвтрэн эзлэхээс сэргийлэх болон улс орны соёлын бат бэх байдал, уламжлах чанарыг хамгаалан авч үлдэх бодлого, үйл ажиллагааны үр дүн болох хэл соёлын аюулгүй байдлын дархлаа тогтоогүй "өндөр эрсдэлтэй" байгааг харуулсан байна.

Эндээс манай улсын соёл иргэншлийн, улмаар оршин тогтнохуй аюулгүй байдлын дархлаа цаашид гадны хэл соёлын түрэлтийн талаар цогц бодлого авч хэрэгжүүлэхгүй бол улам доройтох дүр зураг харагдаж байна.

Энэ сценарын үед манай улс Америк, Оросын болон НҮБ-ын дэмжлэгтэйгаар төвч байр суурь баримталж болох таамаглал байна.

Гуравдагч орны хувьд: Хантингтон БНХАУ-ын нөлөө нэмэгдэхийн хэрээр Азийн улс орнууд түүнийг дагаж дараах байдлаар ханарах болно гэжээ. Үүнд:

- Хятадаас цагаачид ирэхийг нэг их хорихгүй;
- Хятадын эсрэг чиглэсэн хөдөлгөөнийг улс орондоо хориглох эсвэл дарах;
- Хятадын эсрэг чиглэсэн эвсэл, холбоонд нэгдэхгүй байх;
- Мандарин хэл хэрэглэхийг өргөтгөн улмаар англи хэлийг халж, дорнод Азид хэрэглэх үндсэн хэрэглүүр болгох;
- Өмнөд Хятадын тэнгис болон Монголд бүрэн эрхээ тогтоохыг дэмжих[64] гэсэн таамаглал дэвшүүлсэн байдгийг анхаарах хэрэгтэй юм.

Б. Америк, Оросын хоорондын соёл иргэншлийн зөрчилдөөнөөс илүүтэй Исламын соёл иргэншилтэй зөрчилдсөн үеийн "холбоотны харилцааны" сценар үүсвэл манай хоёр том хөршийн хооронд хамтын ажиллагаа хэвийн үргэлжлэх магадлал өндөр байна.

Монгол Улсын аюулгүй байдлын хувьд өөрийн үндэстний цөөнхийн талаар оновчтой бодлого явуулах, гаднаас дүрвэгсэд орж ирж болзошгүй нөхцөлд бэлэн байх, терроризмын аюул заналаас сэргийлэхэд илүүтэй анхаарах шаардлага гарна. Хоёр хөрш гүрэн болон гуравдагч оронтой харилцах бодлого хэвийн үргэлжлэх болно. НҮБ-ын байр суурийг дэмжинэ.

3.3. ОХУ, БНХАУ-ын хооронд үүсэж болзошгүй харилцааны Монгол Улсын аюулгүй байдалд учрах боломж, эрсдэл

3.3.1. Орос, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хэвийн үргэлжлэх үеийн боломж:

[64] Samuel P.Huntington "The Clash of Civilizations and the Remaking of World Order" Touchstone Book 1996, p.183

Үндэсний аюулгүй аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан хоёр хөршийн болон “гуравдагч хөрш”-ийн талаар баримтлах ухаалаг бодлого явуулбал манай улсын аюулгүй байдлын хэтийн төлөв ихээхэн эерэг төсөөлөлтэй байна.

Хятадын “Бүс, зам” стратегийн хүрээнд Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридорыг төлөвлөлтийн дагуу хөгжүүлэх боломж байна.

Харин энэхүү хамтын ажиллагаа юунд хүргэж болзошгүй хэтийн төлөв байгаа талаар доктор Р.Болд *“Хэзээ ч юм ирээдүйд тохиох 1919 оныхтай адил хэрэг явдлын угтал нь Монгол, Орос, Хятадын 2015 оны "шинэ цагийн Хиагтын" гурвалсан тохиролцоо юм. Энэхүү тохиролцооны ойрын болон дунд хугацааны үр ашиг нь Монголын хөгжил, дэвшилд чухал ач холбогдолтой байж болно, харин хэтийн үр дагавар нь Монгол дахин "дагуул" улс болоход хүрнэ.”*[65] гэсэн таамаглал дэвшүүлсэн нь анхаарал татаж байна.

Ийм байдалд хүргэж болзошгүй төлөвийн талаар мөн гадны судлаач “Монголчууд бараг бүх түүхий эд материал нь Хятад руу явдгийг, улс төр эдийн засагт нь Хятадын нөлөө улам ихсэж байгааг мэддэг хэдий ч энэ талаар ямар ч дорвитой арга хэмжээ авдаггүй” гэсэн байна.

Ер нь Хятад улсын зүгээс манайх руу хандаж буй хэтийн хандлагын ерөнхий зураглалыг БНХАУ-ын Нийгмийн ШУА-ийн Дэлхийн эдийн засаг, улс төрийн бодлогын хүрээлэнгийн Олон улсын стратегийн тэнхимийн эрхлэгч Суе Ли "хөршүүдээ" ач холбогдлоор нь дөрөв ангилж, тэдэнтэй харилцан адилгүй харилцах зарчмыг тодорхойлсноос харж болно. Үүнд:

нэгд, салбар бүс нутгийн их гүрнүүдтэй (Орос, Австрали, Казакстан, Япон, Энэтхэг, Вьетнам, Индонез) "тэнцвэржүүлэх хамтын ажиллагаа явуулах" зарчмаар,

хоёрт, салбар бүс нутгийн хоёрдугаар зэргийн гүрнүүдтэй "чин сэтгэлийн гэхдээ хязгаарлагдмал дэмжлэг үзүүлэх" зарчмаар,

гуравт, Хятадтай нягт харилцаатай салбар бүс нутгийн жижиг, дунд улсуудтай (БНАСАУ) "баталгаа өгөхгүйгээр бүхий л дэмжлэг үзүүлэх" зарчмаар,

дөрөвт, бусад жижиг, дунд улсууд (Монгол), эдгээртэй "тодорхой салбар, аргачлалаар хязгаарлагдсан хамтын ажиллагаа"-ны зарчмаар тус тус харилцана гэжээ.[66] Тэрээр Оросыг зөвхөн бүс нутгийн гүрэн гэж үзэн, төслийн хүрээнд

[65] "XX зууны Монгол: түүх, соёл, геополитик, гадаад харилцааны тулгамдсан асуудлууд" УБ 2017 номонд хэвлэгдсэн өгүүллэг

[66] Xue Li and Zheng Yuwen “A Blueprint for China’s Neighborhood Diplomacy” The Diplomat March 30, 2016

Казакстан, Вьетнамд тэргүүлэх ач холбогдол өгөх, БНАСАУ-ыг Монголоос дээгүүр авч үзэх, харин Монголтой бол хязгаартай, үзэмжээрээ харилцах зарчмыг дэвшүүлсэн байгааг доктор Р.Болд онцолсон байна.

Иймэрхүү хэтийн төлөвөөс сэргийлэх бодлого талаас харвал философич, эрдэмтэн Б.Даш-Ёндон бичихдээ "Монгол өөрийгөө оюуны хувьд оношилвол дараах онцлогийг анзаарах ёстой, эдүгээ дэлхий дахинаа "цусгүй дайн" буюу ноцтой өрсөлдөөн болж байна, энэ өрсөлдөөнд дэлхийн бүх улс орон татагдан оров. Эл өрсөлдөөний гол агуулга нь:

а.) Цөөн хэдэн их гүрэн дэлхий дахинд манлайллаа тогтоох гэж хоорондоо алсын ухаангүй өрсөлдөж байгаа;

б.) Жижиг буурай орнууд тэсэж үлдэхийн төлөө тэмцэлдэж байгаа;

с.) Дунд зиндааны улс орнууд чадвал их гүрэн болох, ядвал одоогийн хүч чадлаа хадгалж, доошоо орчихгүйн төлөө тэмцэж байгаа зэрэгт оршино. Ийм нөхцөлд монголчууд бид оршин тогтнохын төлөө, тэгэхээр хөгжихийн төлөө, ингэхлээр үндэсний аюулгүй, улс орныхоо тусгаар тогтнолыг бүх талаар хамгаалан бататгахын төлөө тодорхой ямар бодлого баримтлах ёстойгоо боловсруулах шаардлага тулгарч байна”[67] гээд "Ер нь олон улсын тавцан дээр ч гэсэн зөвхөн дундаж бодлого л бие даасан бодлого болж чадна гэдгийг анхаарах нь зүйтэй. Дэлхийн их гүрнүүд, бусад томоохон гүрнүүдийн өрсөлдөөн дундаас Монгол Улс өөрийнхөө сонирхолд нийцэхийг нь судлан олж голлон харгалздаг байх нь нэн чухал юм"[68] гэж онцолсоныг болон шинжлэх ухааны доктор, профессор Д.Уламбаяр "гуравдагч хөрш"-ийн бодлогоо хэрэгжүүлэх гадаад орчин 1990-ээд оноос үндсээрээ өөрчлөгдсөнийг харгалзах ёстой гэсэн дүн шинжилгээ хийгээд “нэг туйлт дэлхийн дэг журам зонхилж байх үеийн "гуравдагч хөрш"-ийн бодлого бол нэг хэрэг, харин эдүгээ олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвшиж байгаа энэ үед "гурвалсан хөршийн" бодлого, "гуравдагч хөрш"-ийн бодлогын хоорондын тэнцвэрийг зөв барих явдал чухал”[69] гэж үзсэн нь энэхүү сценарын үед бодолцох чухал санаа юм. *Эндээс хоёр хөрш гүрэн хоорондоо найрсаг хамтын ажиллагаа өрнүүлж байх таатай сценарын үед ч Монгол Улсын бүрэн эрхт байдалд эрсдэл учирч болзошгүй байгааг харуулж байна.*

[67] Б.Даш-Ёндон “Нийгмийг танихуй:түүх-хөгжлийн философи” УБ. 2014, т.224-226
[68] Мөн тэнд, т.267
[69] Д.Уламбаяр "Монгол Улсын гадаад бодлогод "гуравдагч хөрш"-ийн бодлогын эзлэх орон зай, ач холбогдол"" "Монгол Улсын гадаад бодлогын лаборатори төсөл"-ийн хүрээнд болсон эрдэм шинжилгээний семинарт тавьсан илтгэл УБ. 2017.05.01

3.3.2. Орос, Хятадын хооронд үүсэж болзошгүй зөрчилдөөний үед учрах эрсдэл:

Цэрэг, улс төрийн хувьд Энэтхэг, Номхон далайн бүс нутагт улам бүр өсөн нэмэгдэж буй АНУ-ын цэрэг-улс төр, эдийн засгийн нөлөөг хязгаарлах үүднээс ШХАБ-ын цэрэг-улс төрийн эвсэл хэлбэрийн үйл ажиллагаа өргөжин, үүний үр дагавраар НАТО, АНУ болон ШХАБ-ын хооронд бие биеийн эсрэг хүчээр заналхийлсэн зөрчил, сөргөлдөөн үүсэж, үүнд Монгол Улс татагдан орох эрсдэл үүсч болзошгүй юм. Монгол Улсад “хадны дунд хавчуулагдсан халиуны зулзага хөөрхий” гэдэг шиг хоёр хөршийн аль аль талаас нь өөрийн талд орохыг шаардсан хүнд дарамт, шахалт ирнэ.

Монгол Улс том л газар нутагтай болохоос биш газар зүйн ашиггүй байрлалтай, стратегийн ач холбогдол нь хоёр хөршид л хэрэгтэй болохоос биш бусдад багахан үүний улмаас олон улсын бодлогод тоглолт явуулах сонголт нь ч хязгаарлагдмал болох нь энэ сценарын үед харагдана. Монгол Улс сөргөлдөгч хоёр талын аль нэгнийх нь талд татагдан орох аюул занал тулгарна. Ийм сценарын үед төвийг сахих оролдлого хийх нь хөрш хоёр гүрний зүгээс дэмжлэг авахгүй байх болно. Харин Д.Тренин "Монгол нь эдүгээ Орос, Хятадын хооронд төвийг сахисан буфер болжээ. Хятад нь бүс нутагтаа хүчирхэг гүрэн болох тусам Улаанбаатар нь Москва болон өөртэй нь улам ойртож буй Бээжингийн хооронд туйлын хянуур хөвөх шаардлагатай болно. Орос нь Алс дорнодод хилийн стратегиа хөгжүүлэхдээ энэхүү байдлыг анхааралдаа авахад хүрнэ"[70] гэсэн байдгийн зэрэгцээ Дорнынхон ОХУ-ыг аюул заналхийлэл гэж нэг их үздэггүй логикоос харвал энэхүү сценарын үед Монгол нь ОХУ-тай цэргийн холбоотны харилцааг сэргээх магадлал байж болох талтай талаар доктор Р.Болд тэмдэглэсэн байна.

Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчны тухайд их гүрнүүдийн хоорондын харилцааны хэтийн төлөвтэй холбоотой эдгээр сценаруудаас гадна нэр хүнд бүхий геополитикийн онолчид олон янзын таамаглал дэвшүүлсэн байгааг манай улс “хар хайрцаг”-ныхаа бодлогод харгалзан үзэх шаардлага ч байж болох юм.

[70] Dmitrii Trenin 2002 The End of Euroasia Russian on the Border Between Geopolitics and Globalization 2002, p.318

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчны мөн чанарын судалж, өнөөгийн байдлыг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон холбогдох бусад бодлогын баримт бичгийн хүрээнд шинжлэн, аюулгүй байдалд нөлөөлж буй олон улсын геополитик, гадаад орчны нөлөөллийг тодорхойлж, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсруулах зорилгоор энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэлээ

Судалгааны ажлын үр дүнд тулгуурлан дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

4.1. Бодлого, эрх зүйн орчны хүрээнд авч хэрэгжүүлэх зөвлөмж

4.1.1. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэчлэх, Үндэсний стратегийг боловсруулж, мөрдөх

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь Үндэсний аюулгүй байдлын стратегийн шинжийг давхар агуулсан зарчмын алдаатай бичиг баримт юм.

Тухайлбал, “Эдийн засгийн аюулгүй байдал” бүрэлдэхүүн хэсгийн 3.2.4.3. “Газрын тосны бүтээгдэхүүнээр нэг орноос шууд хараат байдлыг багасгаж, улмаар 2020 он гэхэд дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээгээ бүрэн хангана. Үнийн хэт хэлбэлзэлд өртөх эрсдэлээс сэргийлж, улсын нөөцийг түүхий нефтээр 6 сараас доошгүй хэмжээнд байлгана” гэсэн нь үзэл баримтлал бус стратегийн шинжтэй заалт юм.

Иймээс дээрх алдаатай байдлыг засахын зэрэгцээ аюулгүй байдлын орчны хурдацтай өөрчлөлттэй уялдаатай аюулын шинж чанар өөрчлөгдөж, таамаглахад бэрхтэй болсон өнөө үед Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг зайлшгүй шинэчлэн, түүнийг хэрэгжүүлэх стратегийг мөн нэн даруй боловсруулж мөрдөх хэрэгцээ шаардлага үүсээд буй.

4.1.2. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал бүх салбарт мөрдөгдөж байх нөхцөлийг бүрдүүлэх

Монгол Улсын хуулиудын “... хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэсэн томьёоллыг “... хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэж томьёолон хэрэгжүүлж байх арга замыг зөвлөж байна.

4.1.3. Үндэсний аюулгүй байдлыг хангахад гадаад, дотоод орчноос нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох

“Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ” гэсэн заалтын дагуу “таатай нөхцөл” бүрдүүлэхийн тулд юуны өмнө гадаад, дотоод орчноос учрах сөрөг хүчин зүйлсийг тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах, сөрөн тэсвэрлэх, даван туулах, дасан зохицох асуудал яригдана. Иймд үндэсний аюулгүй байдлыг хангах бүрэлдэхүүн хэсэг тус бүрт нөлөөлөх гадаад, дотоод эрсдэлт хүчин зүйлс, хангах арга замыг тодорхойлон тусгахыг зөвлөж байна.

1994 оны Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дээр 9 бүрэлдэхүүн хэсэг тус бүрт нөлөөлөх сөрөг хүчин зүйл, хангах арга замыг тусгаж өгсөн байсан нь хэрэгжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ, үнэлгээ хийхэд хийхэд илүү дөхөмтэй байсан.

Болзошгүй сөрөг хүчин зүйлс ил тод бус байгаа нь аюулгүй байдлын чухал асуудлуудыг анхаарлын гадна үлдээхэд нөлөөлөх үндэслэлтэй юм.

4.1.4. Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудал дээр Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд 3 санал нэгдэж байж, УИХ-аар хэлэлцүүлэн, шийдвэр гаргадаг байх.

Монгол Улсын Үндсэн хуулинд Ерөнхийлөгч “Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах”[71] бүрэн эрхтэй байхаар тусгасны нэгэн адилаар Ерөнхийлөгч олон улсын тавцанд гадаад бодлогын санаачилга дэвшүүлэхийн өмнө нь УИХ-тай зөвшилцөх эрх зүйн зохицуулалттай болох нь зүйтэй.

4.2. Бодлогын хэрэгжилтийг сайжруулах талаарх зөвлөмж

4.2.1. Монгол Улсын хувьд аюулгүй байдлын гадаад орчны хамгийн таагүй нөхцлүүдийн нэг нь нь “хоёр хөрш нэг нь нөгөөгөөсөө хараат байх нөхцөл” юм. Тиймээс ОХУ эдийн засгийн хувьд БНХАУ-аас хамааралтай болж буй нь урт хугацаандаа Монгол Улсад бодит эрсдлийг дагуулах ч магадлалтай юм.

Хоёр хөршийн нэг нь нөгөөгөөсөө хэт хүчтэй болвол Монгол Улс хоёр хөрштэйгөө тэнцвэртэй харилцах боломж улам бүр хязгаарлагдах эрсдэл бий.

[71] “Монгол Улсын Үндсэн хууль” 1992.01.13, 33.1.4-р зүйл

Харин хоёр хөрш хүч, нөлөөний хувьд ойролцоо, өөр хоорондоо болон Монгол Улстай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсыг аль нэг хөршийнхөө нөлөөнд хэт автахаас нөгөө хөрш нь шууд болон шууд бус замаар сэргийлэх нөхцлийг бүрдүүлнэ.

Тиймээс гурван талт болон хоёр талт хамтын ажиллагаа, яриа хэлэлцээний хүрээнд хийгдэх дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг Монгол Улсын эдийн засагт үр өгөөжтэй, аюулгүй байдалд нөлөө үзүүлэхүйц байдлаар хэрэгжүүлж, хоёр хөрштэйгөө нэгэн зэрэг түншлэлийн харилцааг хөгжүүлж, тэнцвэртэй хамтран ажиллах боломжийг бүрдүүлэхийг зөвлөж байна.

4.2.2 . “Гуравдагч хөрш”-ийн бодлого нь манай хоёр хөршийн эсрэг чиглээгүй, бусадтай холбоотон болох биш, бусдын ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх төдийгүй болзошгүй аюул заналхийлэл, түрэмгийллийг саармагжуулах зорилгыг хангах явдлыг удирдлага болгох нь зүйтэй.

Дээрх нөхцлүүд хангагдахгүй аваас Монгол Улсын “Гуравдагч хөрш”-ийн бодлогод эрсдэл учрах магадлалтай.

4.2.3. Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалын “энхийг эрхэмлэсэн гадаад бодлогоо тууштай баримтлах”[72] “олон улсын энхийг дэмжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцох”[73] заалтууд өөр хоорондоо харшилдаж буй эсэхийг нарийвчлан шинжлэх, НАТО-ийн энхийг дэмжих ажиллагаанд оролцох нь Монгол Улсын энхийг эрхэмлэсэн гадаад бодлогын зарчимд нийцэж буй эсэхийг судлаж, шинжээчид болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнууд нэгдмэл ойлголттой байхыг зөвлөж байна.

Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалд “НАТО-гийн гишүүн орнуудтай аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлэх”-ээр тусгасан нь НАТО-гийн гишүүн, тусгаар тогтносон улс орнуудтай хоёр талт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай заалт бөгөөд харин НАТО-той бие даасан бүтэц талаас нь харилцаж, хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай заалт тусаагүй болно.

НАТО хамтын батлан хамгаалах бүтэц буюу цэргийн эвслийн шинжтэй байгууллага тул тус байгууллагатай бие даасан субъект талаас нь хамтын ажиллагааг хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын зарчимд нийцэх эсэх асуудал одоог хүртэл маргаан дагуулсан хэвээр байна.

---

[72] “Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал” 2010.07.15, 3.1.1.3-р заалт
[73] “Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал” 2010.07.15, 3.1.1.6-р заалт

Бодлогын баримт бичгүүдэд энэ төрлийн байгууллагуудтай хамтран ажиллах, түншлэлийн харилцааг хөгжүүлэхийг хориглосон ямар нэг заалт тусаагүй ч “Монгол Улсад гадны цэргийн аюул занал учраагүй нөхцөлд цэргийн аливаа холбоонд нэгдэхгүй”[74] байхаар тусгасныг харгалзан үзвэл НАТО болон энэ төрлийн бусад байгууллагад нэгдэх нь бодлогын баримт бичгүүдтэй шууд харшилдах алхам болно.

4.2.4. Олон улсын байгууллагад нэгдэх, тэдэнтэй хамтран ажиллахдаа элсэн орох байгууллагын бодлого, хэв шинж, үйл ажиллагааны чиглэл нь Монгол Улсын гадаад бодлогын тулгуур зарчимтай уялдаж буй эсэхэд няхуур хандахыг зөвлөж байна.

Монгол Улс аливаа олон улсын байгууллагад элсэхээ тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, хэтийн төлөвийн талаар болон дэлхий нийтээр тухайн байгууллагыг хэрхэн авч үздэг талаар судалгаа явуулж, нэгдсэн дүгнэлт гаргасны үндсэн дээр элсэх эсэх асуудлыг шийдэх нь зүйтэй юм.

Монгол Улс ШХАБ-ын анхны ажиглагч орныхоо хувьд хэзээ нэгэн цагт тус байгууллагад элсэх боломжийг үгүйсгэх аргагүй. Тэгэхдээ олон улсын болон дотоодын зарим шинжээчдийн дунд ШХАБ алс хэтдээ цэргийн эвсэл болж төлөвших магадлалтай, тиймээс тус байгууллагад элсэх нь Монгол Улсын гадаад бодлогын зарчимд харшилна гэж үзэх хандлага байсаар байна.

ШХАБ-ын хүрээнд байгуулсан гэрээ, хэлэлцээр, баримт бичгүүдийг манай Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам сайтар судлан, аль нь Монголд ээлтэй, аль нь Монголд халтайг ялгаж салгаж, дүгнэлт гарган, ҮАБЗ-д өргөн барьж, төрийн өндөрлөгүүдийн сонорт нэн даруй хүргэх нь зүйтэй болов уу. Тэр дундаа Монгол Улсын нийгэм-эдийн засаг, дэд бүтцийн бүтээн байгуулалтад ШХАБ тус нэмэр болох ямар, ямар баримт бичиг мөрддөг, тэр нь ямар заалттай, хэрэгжих ямар үндэслэлтэй, Монголын талаас юу шаардах, Монгол Улс дотооддоо ямар бэлтгэлтэй байх ёстойг олон талаас нь нарийвчлан тооцсон судалгаа, дүгнэлт нэн хэрэгтэй байна.[75]

[74] “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал” Улаанбаатар, 2011, 2.11-р зүйл
[75] Д.Баярхүү- “ШХАБ ба “Нэг бүс-Нэг зам” Хятад ба Орос”, Улаанбаатар, 2018, 118-р тал

ЭШЛЭЛ АВСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

1. Д.Мягмар, Г.Сүхээ “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал: шинэ нөхцөл байдал, тодотгон шинэчлэх шаардлага”. Стратеги судлал. УБ., 2006 №03
2. Г.Баасанхүү ба бусад- “Олон улсын харилцааны үндэс ба даяаршил” УБ, 2016.
3. “Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал” 2010.07.15
4. М.Батчимэг- “Шатрын өрөг дэх Монгол Улс” УБ, 2012.
5. Г.Төмөрчулуун- “Даяар Ертөнц: Монголын геополитик, дипломат ажиллагаа”, Улаанбаатар., 2009.
6. Г.Төмөрчулуун- “Монголын гадаад бодлого XX, XXI зууны зааг дээр” Улаанбаатар., 2016.
7. Р.Болд- “Монголын Геополитикийн зарим асуудлууд” Улаанбаатар, 2019.
8. David H. Capie- “*The Asia Pacific Security Lexicon”* 2007.
9. Хенри Киссинжер- “*Дипломат үйл ажил.*” Орчуулсан Д. Чулуундорж. УБ. 2012.
10. “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”. 2011.
11. Батлан хамгаалах бодллогын үндэс” баримт бичиг. 2015.
12. “Монгол Улсын Үндсэн хууль” 1992.01.13
13. Э.Уранцэцэг- “Төвийг сахих Монгол” 2015.10.21 https://news.mn/r/707478/
14. Байнга төвийг сахих хуулийг санаачлагчид нь буцаав. https://montsame.gov.mn/mn/read/38373. 2016.11.17
15. “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам” Монгол Улсын Засгийн газрын 169 дүгээр тогтоол., 2013.05.16
16. “The Harper Dictionary of Modern Thought” Edited by Allan Bullock and Oliver Stallybass 1977.
17. Монгол Улсын Үндэсний статистикийн хороо
18. О.Машбат- “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын баримтлал ба гуравдагч хөршийн бодлогын хязгаар”“Их гүрнүүдийн хүрээлэлд орших улсын бодлого: Монгол Улсын “Гуравдагч хөрш”-ийн бодлого” эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. УБ. 2011.

19. И. Очирбал- Монгол Улсын гадаад бодлогын анхны үзэл баримтлал батлагдсаны 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал дээр хэлсэн үг.” УБ. 2014.
20. Д. Мягмар, А. Түвшинтөгс, Ж. Чойнхор- “Гуравдагч хөршийн бодлого: Түүхэн уламжлал, өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” өгүүлэл Д. Мягмар- “Аюулгүй байдлын судалгааны зарим асуудал (түүвэр эмхэтгэл)”. УБ. 2012.
21. Д. Мөнхтөр- *Монгол Улсын гадаад бодлогын анхны үзэл баримтлал батлагдсаны 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал дээр хэлсэн үг.”* УБ. 2014.
22. НАТО-ийн албан ёсны цахим хуудас https://www.nato.int/cps/en/natohq/51288.htm
23. Ч.Агваандамдин- “Тусгаар тогтнол ба дипломат бодлого, үйл ажиллагаа” Улаанбаатар, 2016.
24. Ж.Энхсайхан- “Монгол Улсын Цөмийн зэвсгээс ангид статус: Цаашид тавих зорилт” илтгэл “Монгол Улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс болгохоор зарласны 25 жил: үр дүн, цаашид тавих зорилт” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ, 2017.
25. Д. Мягмар- “*Геополитикийн шинэ нөхцөл байдал: Их гүрнүүдийн геостратегийн ашиг сонирхлын дунд.*” “Орчин үеийн олон улсын харилцааны шинэ чиг хандлага ба Монгол улс” эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ. 2011.
26. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын материал. УБ., 2014. Д.Мөнхтөрийн хэсэн үг.
27. Удирдлагын Акакдемиас хэвлүүлсэн "Нээлттэй лекц: 2016-2017 оны хичээлийн жил", УБ ,2017 эмхтгэл.
28. Robert Scalapino “Major Power Relations an Northeast Asia” The Asia Socierty 1987.
29. “America’s Role in Asia” The Asia Foundation 2015.
30. Samuel P.Huntington “The Clash of Civilizations and the Remaking of World Order” Touchstone Book 1996.
31. Шинэ төмөр зам төсөл

32. “Examining the debt implications from the Belt and Road Initiative https://www.cgdev.org/publication/examining-debt-implications-belt-and-road-initiative-a-policyperspective
33. Параг Ханна. Дэлхийн соёл иргэншлийн ирээдүйг зураглахуй ХОЛБОЛТЫН ГАЗАРЗҮЙ. УБ., 2018.
34. Конрад зайц” Хятад дэлхийн гүрэн эргэн ирж байна” УБ., 2009.
35. Ж.Бадамсүрэн “Монголчуудын нутгийн аялгууг хэл хамгаалах бодлогын хүрээнд судалсан нь”, УБ., 2014.
36. Т.Өсөхжаргал. “Монгол хэл соёлын дархлаа бий болгох зарим арга зам” сэдэвт аюулгүй байдлын ухааны докторын диссертац. УБ., 2016
37. "XX зууны Монгол: түүх, соёл, геополитик, гадаад харилцааны тулгамдсан асуудлууд" УБ., 2017.
38. Xue Li and Zheng Yuwen “A Blueprint for China’s Neighborhood Diplomacy” The Diplomat March 30, 2016
39. Б.Даш-Ёндон “Нийгмийг танихуй:түүх-хөгжлийн философи” УБ. 2014.
40. У.Уламбаяр "Монгол Улсын гадаад бодлогод "гуравдагч хөрш"-ийн бодлогын эзлэх орон зай, ач холбогдол"" "Монгол Улсын гадаад бодлогын лаборатори төсөл"-ийн хүрээнд болсон эрдэм шинжилгээний семинарт тавьсан илтгэл УБ. 2017.05.01
41. Dmitrii Trenin 2002 The End of Euroasia Russian on the Border Between Geopolitics and Globalization 2002.
42. Д.Баярхүү- “ШХАБ ба “Нэг бүс-Нэг зам” Хятад ба Орос”, Улаанбаатар, 2018.